

НИЙТЛЭЛ

Барга Эрдэмбилэг: Хүний гарт

Оохнойн Батсайхан^{ID}

Sc.D, профессор

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

batsaikhano@mas.ac.mn

Хураангуй: 1988-1989 онд Нийгмийн ухааны институт Намын ахмад гишүүдийн дурдатгалын V ботийг бэлтгэх үед миний бие Улаанбаатар хотод амьдарч байсан Барга Эрдэмбилэг гуайтай хэд хэдэн удаа уулзан ярилцлага авсан юм. Тухайн үеийн нийгмийн уур амьсгал өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр нээлттэй болж, өмнө нь хэлмэгдсэн нам, төрийн зүтгэлтнүүд, тухайлбал, Дашийн Дамба, Ч.Сүрэнжав, Б.Ширэндэв зэрэг хүмүүс манай институтэд ирж ярилцлага хийдэг болсон цаг үе байв. Эрдэмбилэг гуай 1920-иод оны Баргад хувьсгалт хөдөлгөөн хэрхэн өрнөж, 1928 оны Баргын бослогод өөрөө ямар үүрэгтэй оролцсон, Зөвлөлтийн Дорнод дахины сургуульд суралцсан, Буянгэмэх зэрэг хувьсгалт ажилтнуудын нууц ажиллагааны талаар маш тодорхой ярьсан нь Баргын хөдөлгөөний дотоод зүй тогтол, баргуудын хүсэл зоригийг илэрхийлсэн чухал баримт болж байна.

Тэрбээр 1938 оны 12 дугаар сард баривчлагдаж, олон сар мөрдөнд хоригдсон бөгөөд дараа нь орчуулагчдын группт орж “ЗХУКН-ын товч түүх”-ийг Ринчин, Дугаржав нарын эрдэмтдийн хамт яаралтай орчуулсан тухайгаа өгүүлсэн. Улмаар 1940 оны эхээр засанд илгээгдэж эм найруулагч, орчуулагч, бага эмчээр ажиллаж байсан зэрэг хэлмэгдүүлэлтийн үеийн нөхцөл байдлыг нэн тодорхой өгүүлэн, өөрийн дурсамжийг хуваалцсан нь тухайн үеийн улс төрийн хэлмэгдүүлэлтийн бодит дүр зургийг шинэ өнцгөөс харах боломж олгож байна хэмээн үзлээ.

Түлхүүр үгс: Барга, Эрдэмбилэг, Өвөр Монгол, Коминтерн, Баргын Хувьсгалт нам, 1928 оны Баргын бослого



Удиртгал

1989 онд Улаанбаатар хотын нэгэн дүүрэгт суух өндөр настай Эрдэмбилэг гуайн гэрт очиж, хэдэн удаа уулзаж, дуртгал яриа миний бие авч билээ. Тухайн үед Нийгмийн ухааны институтээс эрхлэн хэвлүүлж байсан Намын ахмад гишүүдийн дурдатгалын 5 дугаар ботийг хэвлүүлэх ажлын хүрээнд хийж байсан ажил байв. 1990 онд Намын ахмад гишүүдийн дурдатгалыг хэвлэхээр бэлтгэсэн боловч мөнгө, санхүүгийн асуудлаас болоод хэвлээгүй билээ.

Т.Бавуудорж, Т.Гэндэн, Ө.Дорж, Г.Эрдэмбилэг нарын ахмад хүмүүсээс яриа авч, уг ботид оруулах ажил над оногдсон юм. 1988-1989 оны үед бол Монголын нийгэмд Зөвлөлт Холбоот Улсад гарч байсан өөрчлөн байгуулалтын нөлөө тусч, шинэчлэлтийн уур амьсгал орж байсан үе байв. Нийгмийн ухааны институтэд өмнө хэлмэгдэж байсан нам, төрийн ахмад зүтгэлтнүүд, тухайлбал, Дашийн Дамба, Ч.Сүрэнжав, Б.Ширэндэв зэрэг хүмүүс ирж, яриа хийдэг байсан үе. Ингээд Баргаас Монголд ирж, улмаар БНМАУ-ын Гэгээрлийн яамны хэлтсийн дарга хүртэл дэвшин ажиллаж байсан Эрдэмбилэг гуайн дурдатгалыг толилуулья. Тэрбээр маш цэгцтэй, 1920-иод оны үед Баргад хувьсгалт хөдөлгөөн хэрхэн өрнөсөн, 1928 оны Баргын бослогод хэрхэн оролцсон тухай, мөн Зөвлөлт Холбоот Улс сурч байсан, дараа нь ирээд Гэгээрлийн яаманд ажиллаж байгаад баривчлагдаж хэлмэгдсэн тухайгаа тодорхой өгүүлсэн юм.

Тухайлбал, Баргад нам хэрхэн байгуулагдсан талаар “Мэхээртэд хувьсгалт байгууллагууд үүсэж Мэрсээ, Пу минтай, Алтанбат гэх мэтийн олон

хувьсгалчид төрж гарсан “, “Гүлхөх хошууны хоршооны дэргэд үнэн хэрэг дээрээ намын байгууллага байсан юм” гээд “Баргын Ардын Хувьсгалт нам эхлээд 1920 онд залуучуудын нам гэдэг нэрээр шинэ Барга-Баруун хошууны Алтан эмээлд байгуулагдсан. Голлон байгуулсан хүн нь Өлзий гуай” гэх зэргээр Баргын хувьсгалт хөдөлгөөний талаар тодорхой зүйлс өгүүлсэн юм.

Түүний ярианы удаах сэдэв нь Улаанбаатар хотод ирээд Шинэ хүчний сургуульд орж, удалгүй Зөвлөлт Холбоот Улсын Ленинград хотын Дорнод дахины сургуульд явсан тухай өгүүлнэ. Тэрбээр Зөвлөлтийн коммунист нам, комсомолын гишүүнд элссэн тухайгаа ч ярьсан. Пунцагдорж, Цэцэнбилэгт зэрэг хэд хэдэн өөр нэрээр Буяннэмэх бээр МАХН-ын нууц даалгавраар барга залуучуудад монгол хэл заахын зэрэгцээ хувьсгалт ажил өрнүүлж явсаныг бас өгүүлсэн буй. 1928 онд Баргад гарсан бослогын талаар өөрөө оролцож, зохион байгуулсан хүний хувьд маш тодорхой зүйлс ярьсан нь онц сонирхолтой байсан юм. Коминтерн, МАХН-ын Төв Хорооноос шийдвэр гарч, нууцаар эл бослогыг өдөөсөн тухай баримт байдаг боловч чухам Баргад бослого хэрхэн дэгдэж, үүний улмаас хичнээн баргууд Монголын талд нүүж орсон талаар сонирхолтой зүйлсийг Эрдэмбилэг гуай ярьсан нь уг үйл явдлын утга, баргуудын бодол санаа, хүсэл зоригийг илүү дэлгэрэнгүй авч үзэх боломж олгох юм.

1988-1989 оны үед гуч дөчөөд оны үеийн улс төрийн хэлмэгдүүлэлтийн асуудал сөхөгдөж, нэр төрийг цагаатгах, уг асуудлыг шинээр авч үзэх боломж нээгдсэн байсан тул

Эрдэмбилэг гуай өөрөө хэрхэн хэлмэгдэлд өртсөн талаар тодорхой өгүүлсэн юм. Тэрбээр “Би 1938 оны 12 дугаар сард баригдаж шоронд орсон. Тэр үеийн харсан, үзсэн баримтаа яримаар санагддаг юм. Би баригдсанаас хойш 7-8 сар мөрдөнд сууж тамлуулаад дараа нь орчуулагчийн группт ажилласан. Дараа нь Төв засанд шилжиж эмнэлэгт 3 жил ажилласан юм. Миний хамт хоригдсон хоригдлууд, хоригдлууд гэдэг нь манай намын гишүүд, цэргийн дарга нар, алба хаагчид шүү дээ” гээд “1939 оны зун 6 сарын үед намайг хорьж байсан камераас гаргаад хөтлөн авчирч, Дотоод яамны барьсан холбоо 2 гэрт орууллаа. Тэгтэл тэнд таньдаг улсууд хэд хэд байв. Хэн, хэн байсан бэ? гэвэл Гэгээрлийн яамны сайд байсан Бадамын Дугаржав, Бямбын Ринчин, Төв хорооны нарийн бичгийн дарга байсан Шижээ, Наваан-Юндэн, Чимэддоржийн Дашням /багш, сэтгүүлч хүн байсан/. Дүгэрсүрэн гэдэг багш, цэргийн яамны орчуулагч эрхээв

Самбуу нар байв. Дээрээс нь нэмээд би орлоо. Бид нарт тусгайлан хоол өгдөг, түлэх түлээтэй нилээд чөлөөтэй байв. Тэгэхдээ орчуулагчийн групп гэдгийг байгуулсан юм байв. Юу орчуулсан бэ? Гэвэл, хамгийн түрүүнд “ЗХУКН-ын товч түүх”-ийг орчуулах ёстой байв. Түүнийг бид яаралтай орчуулсан хоёр сар ч болоогүй, сар гаруй хугацаанд л орчуулсан. Гол ажлыг Ринчин, Дугаржав гуай хоёр л хийсэн” хэмээн ярьсан билээ.

Улмаар Эрдэмбилэг гуай “засанд 1940 оны намар очоод Аптекийн эм найруулагчаар ажиллахын зэрэгцээ Горбаренко гэх эмчийн орчуулагч болов. Түүнийг дагасаар яваад л бага эмч болж, бүр итгэл аваад амбулаторын үзлэг хийдэг эмч болсон” зэрэг хэлмэгдүүлэлтийн үеийн нөхцөл байдлыг илүү тодорхой өгүүлсэн тул түүний дурдатгал сонирхолтой төдийгүй тэр үеийн түүхийн зарим асуудлыг тодруулахад дөхөм үзүүлэх нь дамжиггүй юм.

Товч намтар

Говолын Эрдэмбилэг Сэцэн хан аймгийн Үнэн сүжигт Илдэн вангийн хошуу, одоогийн Дорнод аймгийн Сүмбэр сумын нутаг Хамар Давааны өвөрт 1903 онд Баргын харъяат ядуу гэр бүлд төржээ. 1909 онд Халхын нутгаас гарч Баргын Хандгайт гэдэгт нүүн очиж, Мэхээрт тосгонд 1923 он хүртэл аж төрөн суужээ. 1923 оноос Харилцан туслалцах хоршоонд морьтой зарлага хийж байсан. 1925-1929 онд Улаанбаатарт Намын анхдугаар сургууль, Ленинград хотноо Дорно Дахины дээд сургуулийг тус тус

төгссөн байна. 1928 онд БХК(б)Н-д элссэн бөгөөд МАХН-д хожим 1961 онд элссэн. 1929-1938 онд БНМАУ-ын Ардын Гэгээрүүлэх Яамны боловсон хүчний хэлтсийн дарга, Багшийн сургуульд Түүхийн багш, 1946-1974 онд Монгол улсын номын сангийн эрхлэгч, Гэгээрлийн яамны хэлтсийн эрхлэгч, Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтэд мэргэжилтэн, Шинжлэх Ухааны Академийн гадаад харилцааны хэлтсийн даргаар ажиллаж байгаад 1974 онд өндөр насны тэтгэвэрт гарсан байна.

1989 онд Эрдэмбилэг гуайн ярьсан яриа

Би 1903 оны туулай жил Халх голын одоогийн Хамар давааны ард Баянтохой гэдэг газар төрсөн. 1904 оны Орос японы дайны үед цаад талаас нь баргачууд наашаа дүрвэх гарч ирсэн юм. Бодоход миний аав, ээж дүрвэж гарч ирсэн улсууд байх л даа. Халх Нөмрөг хошууны¹ Баянтохой гэдэг газар нилээд хэдэн жил нутаглаж, оршин суусан. Уг нь цаанаасаа олон хошуу анх нүүж ирсэн боловч, хөрөнгө зорь, мал адуутай улсууд нь буцаад нүүгээд явсан, цочоод айл

бургасан дотор үлдсэн юм. Ингээд би тэнд төрж, зургаан нас хүртлээ амьдарсан. Миний аав өвчтэй учраас манайх ээжийн дүү нагацыг дагаж Халх голын цаана Хандгайт гэдэг газар нүүн очиж Мэхээрт гэдэг тосгонд суурьшлаа. Мэхээртэд голдуу суурин суудаг, суурин аж ахуйтай дагуурууд² амьдардаг байсан. Тэнд миний аавын ах хашаа байшинтай байнгын суудаг дагуур хүн байсан юм. Манайх энд өвөөгөө дагаж аж төрж би тэнд 19 нас хүртлээ өслөө.

Баргын хувьсгалт хөдөлгөөний тухай

1921 оны ардын хувьсгал байгууллагууд үүсэж Мэрсээ³, ялсны дараа Мэхээртэд хувьсгалт

¹ Нөмрөг хошуу гэж Халх Нөмрөг голын хошууг хэлжээ. Хуучнаар Сэцэн хан аймгийн Илдэн засгийн хошуу, 1923 оны засаг захиргааны өөрчлөлтөөр Хан Хэнтий уулын аймгийн Халх голын хошуу хэмээн өөрчилж, Баянцагаан, Буйр нуур, Түмэнцогт, Халх гол, Хунд ташгай, Цагаан уул зэрэг 6 сумтай болжээ. 1926 онд Хан Чандмань уулын (хуучин Сэцэн хан аймгийн Эрхэмсэг засгийн хошуу) хошууг татан буулгаж тус хошуунд нийлүүлэв. 1929 онд Халх голын буриад хошууг татан буулгаж тус хошуунд нийлүүлэн Халх Нөмрөг голын хошуу хэмээн нэрлэгдэх болов. 1931 онд хошуудыг татан буулгахад тус хошууны нутгаар одоогийн Дорнод аймгийн Халхгол сумыг байгуулсан байна.

² Дагуурууд Өвөр Монголын Хөлөнбуйрын Мориндаваа - Дагуурын өөртөө засах хошуундаа голчлон суудаг. 2000 оны байдлаар Өвөр Монголд 77,188 (үүнээс Хөлөнбуйрт 70,287), Хармөрөнд 43,608 тоотой дагуур хүн амьдарч байна гэсэн баримт байдаг.

³ Говал халын Мэрсээ Шинэ Барга, Баруун гарын Хөвөөт шар хошууны нэгдүгээр сумын харьяат, Тэрбээр 1894 онд Хөлөнбуйрын Солон хошууны дэд дарга Гүйлүгийн хөвүүн болон Зүүн өмнө Мэхээртэд төрсөн. Монгол, манж, хятад, англи, орос хэлтэй. 1920 оноос хувийн хөрөнгөөр сургууль байгуулж, Хөлөнбуйрын сургуулийн хэргийг эрхэлж, барга монгол хүүхдүүдэд боловсрол олгохыг чухалчилж байв. Удалгүй Баргын Хувьсгалт хөдөлгөөнд хамгийн ихээр идэвхтэй оролцогчдын нэг бөгөөд Улаанбаатар хотод ирж, Баргын Ардын Нам байгуулах ажилд биечлэн зүтгэсэн хүн юм. Хөлөнбуйрын оюутны зөвлөл 1923-1924 онуудад МАХН-тай улс төрийн талаар хамтран ажиллах гэрээ байгуулж, оюутны зөвлөлийн нэрээ “Хөлөн-буйрын залуучуудын нам” болгон өөрчилж, Мэрсээ, Буянгэрэл нарыг даргаар нь сонгосон байна. Энэ үед Мэрсээ нь Монгол улсын Үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлийн удирдах албан тушаалд сонгогдон ажиллаж байсан ба улмаар ЗХУ-д Монголын ҮЭ-ийн нэрийн өмнөөс төлөөлөгчөөр явж байжээ. Мэрсээ нь 1925 онд Өвөр Монголын хувьсгалчидтай холбоо тогтоон Жанчхүү хотноо Өвөр Монголын ардын хувьсгалт намыг байгуулжээ. Мэрсээ Баргын хувьсгалт хөдөлгөөнд оролцохдоо Хөлөн-буйрын бие даасан байдлыг хэрхэн хангаж, Хөлөнбуйрын монголчуудад эрх чөлөө олгож, соён гэгээрүүлэхийг зорилгоо болгосон байна. Тиймээс Баргад хувьсгалт хөдөлгөөн идэвхжүүлэх нь Мэрсээ Хөлөн-буйрын автономит эрхийг даруй эргүүлэн авах боломж хэмээн Мэрсээ үзэж, МАХН-ын удирдлагад зэвсэгт бослого Баргад зохион байгуулах саналыг удаа дараа тавьж байжээ. Гүйлүгийн Мэрсээ Баргын хувьсгалч, Өвөр монголын ардын хувьсгалт намын үүсгэн байгуулагч, удирдагчын нэг, монгол үндэстэн юм. Энэ үед Мэрсээ нь хятадад

Пу минтай⁴, Алтанбат⁵ гэх мэтийн олон хувьсгалчид төрж гарсан юм. 1922 оны билүү, 1923 оны намар Хайлаар⁶ хотод (энэ хот бол тэр үеийн Орос, Хятад худалдаачид наймаа хийдэг дамжлага газар байсан юм) Ардын засагт Монгол улсын харилцан туслалцах хоршооны салбар байгуулагдсан. Энэ салбар бараагаа нааш нь Улаанбаатар хотод Баянтүмэнээр⁷ дамжуулж явуулдаг байв. Салбарын эрхлэгч нь Шелонин гэдэг коммунист, орос хүн байсан.

Тэр хоршоо бол хувьсгалчдын Монгол улстай харилцах гол төв нь болж байв. Хоршооны дэргэд намын үүр, хороо байсан ба Мэрсээ, Пу минтай нар наашаагаа хоршооны нэрээр явдаг байсан. Би 1923 оны хавар байхаа, Хоршоонд морьтой зарлагаар /холд явдаг/ орлоо. Яагаад намайг морьтой зарлагаар авсан бэ гэхээр би бол тэнд төрсөн. Халх голын замыг сайн мэддэг байсан юм. Тэдгээр гол хувьсгалчдын дотор бүдүүн Цэрэнгийн эцэг Өлзий⁸ гэдэг хүн байсан. Уг нь Барга хүн

Баруун хойд орны хянан шийтгэх түшмэлийн газарт зөвлөхийн албан тушаалд ажиллаж байсан байна. Гоминдан нам 1926-1927 онуудад коммунистуудтай холбоогоо тасалж, үүний нөлөөгөөр Өвөр Монголын АХН-ыхныг мөрдөн мөшгиж эхэлжээ. ӨМАХН-ын дотоодод ч бас үзэл бодлын хагарал гарч, намын гишүүн харчин Цэрэндонров Чай Кай Ши-гийн талд урван орж нөхдөө барьж өгч, өөрөө Гоминданы талаас өндөр шан харамж аваад Тайвань арал руу оргон гарсан байна. Ийнхүү Хөлөнбуйрын Залуучуудын нам төрөлх Солон руугаа дахин буцсан ажээ. Мөн ӨМАХН Жанчхүү хотноо байрлах боломжгүй болсон тул Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо шилжин ирж, МАХН-ын шууд удирдлагын дор ӨМАХН-ынхаа үйл ажиллагааг явуулж байжээ. Хөлөнбуйрын Залуучуудын нам 1928 оны зун Баргын баруун өмнө хязгаар Монгол улсын хил болох Сүмбэр хэмээх газар нууцаар намын төлөөлөгчдийн их хурлыг хуралдаж, Хөлөнбуйрын автономит эрхийг сэргээх зэвсэгт тэмцэл хийж тусгаар тогтнолоо тунхаглахаар тогтож, Хайлаар хот, Хянганы нуруу, Манжуур хот зэргийн гурван чиглэлээр давшин орохоор шийдвэр гаргав. Мөн оны 7-р сард Мэрсээгийн удирдлагын дор Залуучуудын намынхан Барга зүүн гарын Шулуун хөх хошууны өмнө хязгаарыг хамгаалах цэргийн анги сууж байсан Хандгайт хэмээх газрыг нууцаар шөнө дайран орж эзэлсэн бөгөөд өөрийн найз Буянгэрэлийг цэргийн зөвлөлийн даргаар томилж, Хөлөнбуйрын ардын цэргийг зохион байгуулж, Хандгайтыг цэргийн гол түшиц газраа болгон, халуун рашааныг эзлэн авч, дараа нь гурван замаар давшин орох төлөвлөгөө зохиосон байна. Мэрсээ бол Нармай Монгол буюу Панмонгол үзлийн томоохон номлогч байсан бөгөөд түүний бичсэн “Шинэ Монгол” хэмээх ном нь Монгол улсыг дэлхий дахинд сурталчилсан анхны англи хэл дээрх ном юм.

⁴ Пу минтай буюу Уул халын Буянгэрэл Барга, Баруун гарын Гүл цагаан хошууны нэгдүгээр сумын харьяат, Зүүн өмнө Мэхээртэд төржээ. Монгол, манж, хятад хэлтэй. Хар мөрөн мужийн дунд сургуульд сурч байжээ. 1923 оны 7 дугаар сард хуралдсан МАН-ын 2 дугаар их хуралд Барга Монголын залуучуудын сургуулийн төлөөлөгч Пу минтай буюу Буянгэрэл баяр хүргэж үг хэлжээ. Хөлөн-буйрын Баргын төлөөлөгч Буянгэрэл буюу Пу минтай 1924 оны 6 дугаар сарын 29-нд МАХН-ын Төв Хороонд Хөлөнбуйрын Баргын тухай бичиг өргөн барьж, түүндээ Халх, Барга нь язгуур үндэс, шашин суртал, газар орон, жаргал зовлон нэгтэй тул монгол үндэстэн бүгдээр хүчин хавсарч, нэгэн сэтгэл, нийтийн хүчээр монгол овогтоны эрх мэдлийг бүрэн бүтэн болгох зорилгоор 1923 оны Халх, Баргын гэрээ бичгийн ёсоор Хөлөн-буйрын эрх мэдлийг эргүүлэн олгох саналыг дэвшүүлэн тавьж байжээ. Тэрбээр Хөлөн-буйрын төлөөлөгчдийн бүрэлдхүүнд багтаж, 1924 оны 8 дугаар сард хуралдсан МАХН-ын 3 дугаар их хуралд оролцжээ. Буянгэрэл Баргын төлөөлөгчидөө төлөөлөн тус их хуралд баяр хүргэж үг хэлсэн байдаг.

⁵ Алтанбат - Говол халын Алтанбат Барга, Баруун гарын Хөвөөт шар хошууны нэгдүгээр сумын харьяат, Зүүн өмнө Мэхээртэд төрсөн. Манж, Хөлөн-буйрт хуучин манж сургуульд сурж байжээ.

⁶ Хайлаар Өвөр Монголын Хөлөнбуйр аймгийн хот юм.

⁷ Баянтүмэн Хөлөнбуйртай хиллэдэг Дорнод аймгийн сум.

⁸ Барга Өлзий Бүдүүн хэмээн алдаршсан Цэрэнгийн Өлзий (1881-1937) Хөлөн-буйрийн Шинэ

Манлай ван Дамдинсүрэнгийн⁹ баруун гар, Сүхбаатарын¹⁰ нууц бүлгэмд¹¹ намын ажил хийж, Хатанбаатар Магсаржавтай¹² баруун замын байлдаанд оролцож, Монголын төлөөлөгчтэй Холбоот улсад явж Ленинтэй уулзсан¹³ гэж хүмүүс ярьдаг. Тамсагийн¹⁴ замаар Халх голоос цааш

Барга зүүн гарын хошууны харьяат, 1911 онд Монгол тусгаар тогтнолоо тунхагласны дараа 1912 онд Нийслэл Хүрээнд ирж, Манлайбаатар Дамдинсүрэнгийн цэрэгт элсэн орж, Ховдыг чөлөөлөх хийгээд тэмцэлд оролцож явсан төдийгүй мөн Долоннуур зэрэг газрын байлдаанд оролцож байжээ. 1920-иод онд Ардын засагт Монголын Их бууны хорооны дарга, Ховдын хязгаарын сайд, Зэвсгийн ангийн дарга, Цэргийн явдлын яамны Цэргийн тагнуулын газарт ажиллаж байсан тагнуулч ажээ. 1920-иод оны үед Коминтерн болон МАХН-ын заавар, чиглэлийн дагуу Хөлөнбуйрт удаа дараа очиж, хувьсгалт үйл ажиллагаа явуулахад идэвхтэй оролцсон байдаг. Төлөөлөгч Өлзий, бичээч Балдангомбын хамт 1924 оны өвөл Тамсагбулагаар дамжин, Халхын гол хүрч, Өвдөг боомтоор хил давж, Баргын найман хошууны нутгаар явж, газар орны байдлыг тандан, ард олонд ардын засгийн бодлогыг сурталчилж явжээ. Ийнхүү явахдаа Баргын найман хошуу, дагуур, солон нараас МАХН-ын Төв Хороонд хандан “бүгдээр Монгол Улстай нэгэн гэр улс” болох хүсэлтээ илэрхийлсэн бичгийг дамжуулж өгсөн байдаг.

⁹ Манлайбаатар Жамсрангийн Дамдинсүрэн нь (1871-1921) нь Богд хаант Монгол улсын цэргийн жанжин, Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэгч байв. Дамдинсүрэн нь Хөлөнбуйр нутгийн уугуул Барга Монгол хүн бөгөөд Шинэ Баргын Шулуун цагаан хошууны суман занги хүн байжээ. 1912 онд Ховдын байлдаанд Дамдинсүрэнгээр удирдуулсан цэрэг ялалт байгуулсныг хөхүүлэн Богд хааны зарлигаар Дамдинсүрэн нь үе улиран залгамжлах засаг төрийн бэйл, хоёр нүдний тогосын отго, цэргийн жанжин, Манлайбаатар цолоор шагнажээ. Эл тухад тэрбээр “Ердийн сумын занги тогосын отго Дамдинсүрэн миний бие Монгол Улсын Олноо өргөгдсөний тэргүүн оны 2 дугаар сард харьяат олныг удирдан Богд эзний өршөөл соёлд чин үнэн сүсгээр дагаар ирсэн” хэмээн бичжээ. Богдхааны зарлигаар Дамдинсүрэнд гүнгийн хэргэм шагнаж, албат ардуудыг нэгэн хошуу болгож, Сэцэн хан аймагт хавсруулан захиргажээ. Монголын тусгаар тогтнолыг хамгаалан, Өвөрмонголын ард түмний тэмцлийг дэмжсэн, Монгол цэргийг удирдан Хятадын түрэмгий цэрэгтэй байлдаж байсан. 1915 оны гурван улсын гэрээ байгуулахад төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд идэвхтэй оролцож байсан. Монгол Улсын Гадаад Хэргийг Бүрд Эрхлэн шийтгэгч Яамны дэд сайд байв. Тэрбээр 1921 онд Хятадын гамин цэргийн гянданд нас баржээ.

¹⁰ Дамдины Сүхбаатар (1893 -1923) нь Монголын ардын намыг үүсгэн байгуулагчдын нэг, төрийн зүтгэлтэн, Монгол улсын Ардын засгийн газрын Цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжин байв.

¹¹ Сүхбаатарын нууц бүлгэм гэж 1920 онд Нийслэл Хүрээнд байгуулагдсан Хүрээний нууц бүлгэмийг хэлжээ.

¹² Хатанбаатар Магсаржав буюу Сандагдоржийн Магсаржав (1878 -1927) нь Монголын цэргийн нэрт жанжин, тусгаар тогтнолын төлөө цогтой тэмцэгч. Хуучнаар Сайн ноён хан аймаг, одоогийн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт төржээ. 1912 оны зун Баруун хязгаарыг төвшитгөн тогтоох сайдаар Баргын Манлайбаатар Дамдинсүрэнгийн хамтаар томилогдон Ховдыг чөлөөлөхөд чухал хувь нэмэр оруулжээ. Тиймээс түүний Ховдыг чөлөөлсөн гарамгай гавьяаг нь үнэлэн Богд Хааны зарлигаар түүнд “Хатанбаатар” цол шагнажээ. 1921 оны 2 дугаар сараас Бүх цэргийн жанжин, 1922 оноос Цэргийн яамны сайдаар тус тус ажиллаж байв. Нийтийн дайсныг устгах тэмцэлд гарамгай гавьяа байгуулсан учир хэмээн тэмдэглэж, түүнийг 1922 онд Зөвлөлт Орос Улсын Улаан тугийн одонгоор шагнажээ. 1921-1924 онд Цэргийн яамны дэд сайд, 1924-1927 онд Цэргийн яамны сайдаар ажиллаж байв.

¹³ Баргын Өлзий гэдэг хүн Ленинтэй уулзсан тухай баримт олж үзээгүй.

¹⁴ Тамсаг -Тамсагбулаг- Монгол Улсын Дорнод аймгийн Халхгол сумын нутагт Чойбалсан хотын төвөөс зүүн урагш 258 км, Сангийн далай, Вангийн цагаан уулнаас зүүн тийш 45 км газарт орших хүйтэн тунгалаг булаг юм. Тамсагбулаг гэдэг нь То вангийн хошууны төвийн сууриас урагш 10 орчим км зайд, Түгээмэлийн булгаас зүүн тийш 5 км орчим газарт хойшоо харсан эргэцгээс ундран гарах булгийг хэлдэг байна.

25 км-т орших Гүлхөх хошууны¹⁵ төв Долоодын хийд¹⁶ дээр хоёрхон гэртэй хоршооны салбар Өлзий гуайн санаачилгаар байгуулагдаж даргаар нь Алтанбат гэдэг хүн ажиллаж байв. Хожим нь тэр Төв Хорооны гишүүн болсон. Би 1923-1925 онд 3 удаа энэ хоршоонд захиа, мэдээ хүргэж билээ.

Баргын хувьсгалын удирдагчид нь тэнд байж чаддаггүй, голдуу л Улаанбаатар руу Ерөнхий сургууль, намын сургуульд явдаг байлаа. Дээрх хоршооны дэргэд үнэн хэрэг дээрээ намын байгууллага байсан юм. Хоршооны дэргэд сургууль байгуулж, хоршооны ажилчдыг голдуу сургаж байсан санагдана. 1925 он гэхэд хоршоо биеэ даасан шинжтэй болж Мэрсээгийн аав Мэнгү Галдаагийн барьж өгсөн дэлгүүр, жижигхэн гуанз, зочид буудалтай боллоо. Баргын Ардын Хувьсгалт нам эхлээд 1920 онд залуучуудын нам гэдэг нэрээр шинэ Барга-Баруун хошууны Алтан эмээлд

байгуулагдсан. Голлон байгуулсан хүн нь Өлзий гуай.¹⁷ 1925 он гэхэд дээрх нам 5 салбартай 300-аад гишүүнтэй болов. Нэг салбар нь Хайлаарт, нөгөө нь Үнчигар хотод, 3 нь хөдөө / Мэхээрт/ хамгийн хүчтэй /Гүл Хөх, Алтан Эмээлд/ байсан. Хувьсгалчдыг Хятадын харгис гамингууд мөрдөж мөшгисөн ийм байдалд намын гишүүд ажиллаж байв.

Мэрсээ, Пу минтай нар голдуу Улаанбаатарт байж, МАХН-ын III их хурал¹⁸, Улсын анхдугаар их хуралд¹⁹ сууцгаасан. Тэд нар хэлсэн үгэндээ гол төлөв бидэнд мөнгө санхүү, хүн хүчний талаар туслаач гэж гуйдаг байсныг сүүлд нь би уншиж мэдсэн.

Ийм учраас МАХН III их хурал НТХ-д дээрх асуудлыг ойрын хугацаанд шийдэж өг гэж даалгасны дагуу 1924 оны намар МАХН-ын Төв Хороо тэр үед Өвөрмонголын Ардын Хувьсгалт Намын Баргын товчоо гэж нэрлэж байсан байгууллагад хүн хүч,

¹⁵ Гүл хөх хошуу - Баргууд 1734 онд Хөлөнбуйрт нүүдэллэн очиж манж найман хошууны зохион байгуулалтанд орж, хошууны нэр нь “цэрэгт барьдаг” тугийн өнгөөр нэрлэгджээ. Барга найман хошуу нь хөвөөт цагаан, хөвөөт хөх, хөвөөт улаан, гүл хөх, гүл цагаан, гүл шар, гүл улаан гэх нэртэй болсон байна. 1919 онд Хөвөөт цагаан хошуу, Шулуун хөх хошууг Шинэ барга хошуу болгосон байна. Эл Шинэ Барга Зүүн гарын Шулуун хөх хошууг Гүл хөх хошуу хэмээн нэрлэж байжээ. Шулуун хөх хошуу нь Шинэ Барга Зүүн гарын хамгийн өмнө талд БНМАУ-ын Дорнод хязгаар Цогтсүмбэр буюу өнөөгийн Монгол Улсын Дорнод аймгийн Халх гол сумтай хил залгаа, ойр байсан тул тус хошууг бослогын гол төв газар болгон сонгожээ.

¹⁶ Долоодын хийд Баргын Гүл хөх хошууны төвд байсан сүм.

¹⁷ Өлзийд МАХН-ын Төв Хорооноос Алс Дорнод хязгаарын Намын Хороо ба Барга Монголын газар томилогдсон төлөөлөгч мөн болохыг баталсан бичиг 1926 оны 1 сарын 11-нд олгосон байна. Баргын хувьсгалт хөдөлгөөнийг Зөвлөлтийн нам, төрөөс эрчимжүүлэх бодлого эл үед баримталж байсан юм. Тухайлбал, 1926 оны 1 сарын 2-нд ирүүлсэн Москвад сууж байсан Монголын Элчин сайдын яамны мэдээнд Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын хүсэлтээр Зөвлөлтийн тал Өлзийг хоёр сурагчийн хамт, мөн Барга, Дотоод Монголд тус бүр дөрвөн сургагч томилж, 100 винтов, зургаан пулеметыг зохих сумын хамт илгээхээр болсоныг дурьдсан байдаг.

¹⁸ МАХН-ын III их хурал 1924 оны 8 дугаар сард болж, Монгол Улсын капиталист бус хөгжлийн замыг тодорхойлсон. Тус хурлаас МАН-ын анхны дарга, Бүх Цэргийн жанжин Солийн Данзан, Залуучуудын эвлэлийн нарийн бичгийн дарга Баваасан нарыг хилс хэрэгт холбогдуулан цаазалсан юм. Хожим 1962 онд цагаадсан.

¹⁹ Улсын анхдугаар их хурал 1924 оны 11 дүгээр сард хуралдаж, БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийг баталсан юм. Тус хуралд Баргын төлөөлөгчөөр Мэрсээ оролцож, баяр хүргэж хэлсэн үгэндээ: “Баргын олон нийтээр Монгол ардын засгийн соёл журамд биширч, хамтран ижилдэхийг итгэмжлэн биширнэ” хэмээсэн байдаг.

санхүү, арга барилын талаар туслах тухай тогтоол шийдвэр²⁰ гарсан бололтой. Энэ тогтоолдоо Дорнод хязгаарын ардын хувьсгалт нам²¹ байгуулсугай гэж заагаад энэ намынхаа нэг салбарыг Баргын салбар болгох, нөгөөг нь Өвөр монголын салбар болгохоор шийдсэн юм байжээ.

1924 оны намар Мэрсээ Баргадаа эргэн ирээд бидний 20-иод хүнийг хуралдуулж Баргын Ардын хувьсгалт намыг байгуулж, түүний товчоог сонголоо. Товчоог 5 хүний бүрэлдэхүүнтэй сонгосон санагдаж байна.

1925 оны нэг өдөр Пу минтай намайг дуудаад: За чамд одоо их хариуцлагатай ажил ногдлоо. Чи тэр нэг байшингаа сайхан засаж цэвэрлэ! Хоршооны дэргэд байгуулсан нягтлан бодохын сургуулийн шинэ багш ирэх боллоо гээд надад 300 төгрөг өгч үүгээр яг өөртөө таарсан костюм, дотуур хувцас, орны даавуу, хоол ундны зүйлсийг авах хэрэгтэй гэсэн даалгавар өглөө. Ингээд 2

хоногийн дараа хуучивтар пальтотой туранхайвтар монгол хүнийг Пу минтай дагуулж орж ирээд энэ бол манай курст монгол хэл заах багш хүн. Чи сайн тусалж бай! Гэж тэр багшийн нэрийг надад Пунцагдорж гэж танилцуулсан. Би өглөө орой хоолыг нь зөөдөг байлаа. Тэгээд 2-3 хоногийн дараа хичээлдээ орж, бидэнд монгол хэл заадаг байлаа. Би халх хүнийг төсөөлдөг байсны хувьд хэлээр нь цахар аялгуутай халх хүн байна гэж гадарласан юм. Пунцагдорж багш маань Буяннэмэх²² хэмээх хүн байсныг би сүүлд нь мэдсэн. Пунцагдорж багш маань ирээд сар гаруй болж, майн нэгэн дөхөж байхад Баргын ардын хувьсгалт намаас 5 хүнийг Улаанбаатар хотноо байгуулагдах Намын анхдугаар төв сургуульд²³ явуул гэсэн хуваарь иржээ. Тэр тавын дотор миний бие орж, бид 1925 оны майн нэгэн өнгөрөөгөөд оргож, Улаанбаатарт ирсэн юм. Би Намын анхдугаар сургуулийн Дотоодыг хамгаалахын ангид сурч байсан. Манай

²⁰ 1924 оны 10 дугаар сарын 22-ны өдөр МАХН-ын Төв Хорооны бүгд хурлаар Мэрсээгийн “Барга ба Дотоод Монголын доторх хэргийн байдал ба намын тухай” илтгэлийг сонсоод, уг асуудлаар маш нууц тогтоол гаргасан байна. Үүнд: “Барга ба Дотоод Монголчуудад намын хэргийг зогсолтгүйгээр нууцаар явуулж, тус газрын нэгэн үндэсний ард түмний эрх чөлөөг лавтай олохын тулд Коминтерноос тусгай заавар, тусламжийг эрвээс зохино” хэмээжээ. Үүгээр Монгол Ардын Нам Барга ба Дотоод Монголд явуулах хувьсгалт хөдөлгөөнийг шууд гартаа авч удирдан чиглүүлэх болжээ.

²¹ МАН-ын Дорнод Хороо 1924 оны 6 сарын 7-ны өдөр Баргын Монгол Ардын Намын хуучин гишүүд болон шинээр элссэн 23 хүн хамтарч хуралдан, МАН-ын Дорнодын Хороо хэмээх байгууллагыг байгуулжээ. Хорооны даргаар Мэрсээ, Говал, дэд даргаар Буянгэрэл, нарийн бичгийн даргаар Адьяабазарыг сонгожээ. Энэхүү Дорнодын Хороо нь МАН-ын салбар байсан байна. Баргын Монгол Ардын Намын Дорнод Ерөнхий Хорооны дарга Мэрсээ тэргүүтэй төлөөлөгчид 1924 оны зун Улаанбаатар хотод иржээ.

²² МАН-ын Төв Хорооноос Буяннэмэхийг Баргын хувьсгалт хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх зорилгоор тусгай төлөөлөгчөөр томилон илгээж байжээ. Тэрбээр МАХН-ын Төв Хороонд илтгэхдээ “Хөлөнбуйрт ирснээс хойш уул намын журам зорилт, үзэл суртлыг залуу идэрчүүдэд таниулахыг оролдож байсаар Мэрсээгийн хамт Чуулалт Хаалганд ирсэн” хэмээн бичгээр мэдэгдсэн байдаг.

²³ Намын анхдугаар төв сургууль гэж тухайн үед Шинэ хүчний дээд сургууль хэмээн нэрлэж байсан, МАХН-ын дээд сургууль юм. Эдүгээ тус сургуулийн байранд Удирдлагын академи байрлаж буй.

анги 25 хүнтэй. Багш нь маань бага Баторун²⁴ гэдэг хүн байлаа. Түүнээс гадна дотоодыг хамгаалахаас хүн ирж хичээл заадаг байсан. Манай захирал Хаянхирваа²⁵ Дотоодыг хамгаалахын комиссар байсан шүү дээ. Ингээд 4-5 сар сургууль хийгээд хойшоо явж, 1925 оны 9 сарын эхээр Ленинградын²⁶ Дорно дахины дээд сургуулийн²⁷ бэлтгэл ангид орсон. Би урьд нь сургууль соёлд яваагүй болохоор дөрвөн аргын тоо гаргаж унших төдий боловсролтой байлаа. Намын сургуульд байхад Авирмэд²⁸ гүн гэж “хэл бичгийн” нэг сайн багш байсан юм. Тэр багш биднийг их л сайн сургасан даа.

Бид Ленинградад 20-уулаа очлоо.²⁹ Генерал Равдан, Намнандорж, Мотоо, Гончиг /одоо амьд/ гэх мэт хүмүүс

байв. Тэнд бид олигтой сурч чадаагүй. Яагаад гэвэл 1925 он бол ЗХУ-ын хамгийн хүнд амьдралтай үе байсан. 36 рублийн стипендтэй³⁰, монгол оюутны байранд амьдардаг байв. Ленинградын Буддын дацангийн³¹ дэргэдэх лам нарын байрны 1, 2 дугаар давхарт бид нар, 3, 4-р давхарт лам нар амьдардаг байв. Тэнд бид их удаагүй. Тэр өвөл нь биднийг Орос айлуудад тараан хуваарилж суулгав. Ингээд бид орос хэлээ түргэн сурлаа. Гэвч бидний олонх нь сурч төгсөж чадаагүй. Бид 20-оос 5 хүн л үлдсэн. Бусад нь цөм өвчин /уушигны бронхит өвчтэй/ зовлонтой болоод буцаж ирсэн. Хоол унд ч муу өдөрт 200 гр талх, махгүй ногоотой шөл иддэг байсан. Тэгээд бид 5 л төгссөн. Ленинградад сурч байсан явдал миний амьдралын эргэлт болсон

²⁴ Баторун Константин Константинович (1900-1942) Хаант Орос улс Эрхүү мужид төрсөн. 1925-1929 онд ЗХУ-ын М.В. Фрунзийн нэрэмжит Цэргийн академид суралцан төгссөн. 1921 оноос Монгол ардын цэргийн штабын даргын туслах, 1921-1922 онд Бүх цэргийн жанжны туслах, 1922 онд Цэрэг, ардыг сурган боловсруулах газарт зааварлагч, 1922 оноос Дотоодыг хамгаалах газарт эсэргүүцэн тагнах хэлтсийн дарга, 1923-1925 он Дотоодыг хамгаалах газрын дарга, 1929-1937 онд Цэргийн ерөнхий сургуульд багш, МАХЦ-ын Жанжин штабын Байлдааны бэлтгэлийн газрын сургагчаар ажиллаж байгаад нутаг буцсан. (Ч.Болдбаатар, Н.Батболд, 2025, хууд. 124)

²⁵ Хаянхирваа Намжилын (1885-1934) 1922 онд ЗОУ дахь Монголын бүрэн эрхт төлөөлөгчийн газар ажиллаж байв. 1923 онд МХЗЭ-ийн Төв Хорооны зохиолын хэлтсийн эрхлэгч, 1924 онд МАХН-ын Төв Хорооны зохиолын хэлтсийн эрхлэгч, 1925-1928 онд Дотоодыг Хамгаалах Газрын комиссар, дарга. 1928-1934 онд Эрүүлийг хамгаалах, Намын Төв сургуулийн захирлын алба хашиж байгаад 1934 онд “Ж.Лхүмбийн хэрэг”-т холбогдуулан хэлмэгдүүлсэн байна. 1968 онд цагаатгасан.

²⁶ Ленинград Санкт Петербург хот ийм нэртэй байв. Анх Нева мөрний эрэг дээр 1 дүгээр Пётр хаан 1703 онд Санкт-Петербург хотын суурийг тавьж 9 жилийн дараа буюу 1712-1918 онуудад Оросын Хаант Улсын нийслэл болжээ. Хотын нэр нь “Гэгээн Петрийн хот” хэмээх утгатай. Тус хотыг байгуулсан I Пётр хааны нэрээр нэрлэгджээ. Дэлхийн нэгдүгээр дайнаас хойш (1914–1924) Петроград гэж нэрлэгдэж байгаад, Владимир Ленинийг нас барахад түүний дурсгалд зориулж Ленинград (1924–1991) гэж нэрлэж байв.

²⁷ Дорно дахины дээд сургууль - Ленинградад байсан коммунист сургуулийг хэлжээ.

²⁸ Авирмэд МАХН-ын Дээд сургуульд олон жилийн турш намын түүх зааж байсан багш юм.

²⁹ Баргаас Улаанбаатарт сурч байсан оюутнуудаас сонгон авч, ЗХУ-д суралцуулахаар илгээсэн бөгөөд нийтдээ 50 гаруй сурагч илгээсэн хэмээдэг.

³⁰ Стипенд - тэтгэлэг.

³¹ Санкт-Петербург хотод 1909-1915 онд Буриадын нэрт лам, эрдэмтэн Агваан Доржиевын санаачилгаар баригдсан Буддын сүмыг хэлжээ. Тус сүмийг бүтээхэд Богд хаант Монгол Улсаас дэмжлэг үзүүлсэн баримт архивт байдаг билээ. Тус сүм 1915 оны 8 сарын 15-ны өдөр нээгдэж байжээ.

юм. Би 1925 онд очоод Зөвлөлтийн залуучуудтай их дотно нөхөрлөж, байр байшин нураах, барих, идэшний ногоо өдөр шөнөгүй зөөх зэрэг ажил хийж байв. Би 1926 онд ЗХУ-ын Комсомол³², үйлдвэрчний гишүүнд, 1928 оны 2-р сард БХК(б)Н-д элссэн.

Манай нам, эвлэлийн байгууллагад чадварлаг сайн улсууд байсан л даа. Голдуу хуучин партизанууд, иргэний дайнд оролцсон хүмүүс, Дорно дахины дээд сургууль монголчуудаас гадна хятад, япон, турк, египет, перс, иран гэх мэт дундад ази, дорно дахины улсуудад ажиллах дипломат ажилтнуудыг бэлтгэх, тэдэнд улс төрийн хэл зан байдлыг сургадаг коммунист сургууль байсан юм. 1000 гаруй оюутантай байсан байх аа. Би 1929 онд сургуулиа төгссөн. Төгссөн намраа эх орондоо ирээд Ардын Гэгээрүүлэх Яамны боловсон хүчний хэлтсийн даргаар томилогдож, 1932 он хүртэл ажилласан. Түүний зэрэгцээ Багшийн сургуульд түүх заадаг байсан. Би насаараа л Ардын гэгээрлийн яамны аппарат, Академийн тэргүүлэгчдийн газар л ажилласан хүн. Би Гэгээрлийн яаманд “Багш” сэтгүүлийн коллегийн гишүүнээр байхдаа нийгмийн ухааны хичээлийн программ зохион, багш нарт семинар өгөх зэргээр заах аргын ажлуудыг хавсарч хийдэг байсан юм. Ялангуяа сурах бичиг байгаагүй учраас багш нарт бүх л өвөл заах хичээлийг нь конспектэлж³³ өгнө шүү дээ. Конспектоор бид амьдарч байлаа. Тэгээд хойноос нь заах аргын захидлаар конспект дээр нь засах

тайлбарлах, нэмэх хасах зүйлээ явуулдаг байсан юм. 1932 оны намар би Багшийн сургуульд түүхийн багшаар очсон. Миний гол ажил энэ байсан юм л даа. Ингээд 1938 он дуустал тэнд ажилласан. 1938 оны 12 сард би баригдсан. Би Зөвлөлтөөс ирэхдээ ЗХУКН-ын гишүүнээр шилжиж ирсэн юм. Энд би Монголын төвийн албан газруудад уригдан ажиллаж байсан сургагч нарын үүрт хуралддаг, тэнд манай Гэгээрлийн Яамны сургагч нар ч /4-5 хүн/ байсан. Би тэр үүрт 10-аад жил багшилж байсан. Ингээд би баривчлагдсан тул намаасаа гарч дахиад орж чадаагүй. МАХН-д орж чадаагүй шалтгаан нь хоёр намд орж болохгүй байсан. Уг нь би МАХН-д 1930 онд орох өргөдөл өгсөн юм. Тийм учраас өргөдлийг минь хүлээж аваагүй. 1928 онд би Ленинградын Дорно дахины дээд сургуулийн 3-р ангид байхдаа зуны амралтаараа Улаанбаатарт ирлээ. Энэ үед Баргад хувьсгал өрнөж, Гоминданыг эсэргүүцсэн бослого хөдөлгөөн гаргаж байв. Иймээс эдгээр хөдөлгөөнийг удирдан чиглүүлэх зорилгоор Өвөрмонголын Ардын хувьсгалт намын төв хорооны тэргүүлэгч гишүүд³⁴ Улаанбаатараас явах болжээ. Би энүүхэнд нэг тайлбар хэлье. Намайг намын анхдугаар сургуульд ирснээс хойш 1925 оны 8 сард МАХН-ын тусламжтайгаар Өвөрмонголын Ардын хувьсгалт намын нэгдүгээр их хурал Чуулалт хаалганд болжээ. Энэ их хуралд МАХН, Коминтернээс их тусалжээ.

³² Комсомол - Зөвлөлтийн залуучуудын байгууллага ийм нэртэй байв. Монголд Хувьсгалт Залуучуудын Эвлэл хэмээх нэртэй адил байгууллага байлаа.

³³ конспектэлж - лекц бэлдэж өгөх

³⁴ Дотоод Монголын Ардын Хувьсгалт намын төв хорооны удирдагчид Мэрсээ, Фуминтай, Буянгэрэл нарыг хэлжээ.

Их хуралд МАХН-аас Дамбадорж³⁵, Коминтерний төлөөлөгч Очиров³⁶ нар очиж, мөн Буяннэмэх суусан байна. Ингээд 1925 оны 8-р сард хуралдсан энэ хурлаараа Өвөрмонголын Ардын хувьсгалт нам гэдэг нэгдсэн нам байгуулжээ. Хурлын тэргүүлэгчдэд 7 хүн сонгосны дотор Мэрсээ, Пу минтай нар орж, дараагаар нь Цэрэндонров³⁷ гэдэг хүн сонгогджээ. Энэ хуралд оролцохдоо Буяннэмэх Цэцэнбилэгт гэдэг нэртэй байсан гэдэг. Тэнд очоод Буяннэмэх нэлээн юм хийсэн хүн шүү. Төв хорооны хэвлэлийг хариуцаж Өвөрмонголын Ардын хувьсгалт намын улаан туг дуулах ёс, намын дүрэм, намын зохион байгуулалтын асуудал, мөн олон шүлэг зохиолуудыг бичсэн. Ер нь бичиг хэргийн гол хүн нь Буяннэмэх байсан байх. Буяннэмэхийг оргож гарсан энэ тэр л гэдэг. Үнэндээ бол манай намаас Өвөрмонголын Ардын хувьсгалт намд туслуулахаар Буяннэмэхийг явуулсан юм.

Данзан, Баваасангийн хэрэгт холбогдсон ч юмуу үгүй ч юмуу бүү мэд дээ. Явуулахдаа тэгж хэлж гаргасан ч юм билүү. Үнэн хэрэгтээ Өвөрмонголын Ардын хувьсгалт намд л туслах зорилготой явуулсан байх гэж би боддог. Өвөрмонголын Ардын хувьсгалт нам удаан амьдарч чадаагүй.

Энэ нам дотроо зөрчилтэй хоёр саланги байсан. Цэрэндонров тэргүүтэй нэг хэсэг нь хятадын гоминданыг түшиж, цаашдаа замаа ч нэгтгээ гэдэг бодлогыг тавьсан байх. Ийм учраас 1926 оноос эхлээд хагарал гарч эхэлсэн. Энд архивт буй материал, Цэрэндонровын захидал зэргээс үзэхэд Мэрсээ, Пу минтай 2-ыг их хавчиж байсан байдаг. Мэрсээг Өвөрмонголын Алашаа / Дээд Монгол/ руу ажлаар томилогдож явахдаа Гоминдан намыг буруушааж тэндээс салж өөртөө тусгаар тогтносон улс болох тухай суртал нэвтрүүлсэн гэж Төв хороонд ажиллахыг нь түр зогсоож, Пу минтай тэнд удаан байж чадаагүй Улаанбаатартаа эргэж ирсэн. Коминтерний төлөөлөгч Очиров Дээд Монголд явж байгаад дээрэмчдэд алуулсан гэж сонссон. Чуулалт хаалгадаа тогтож чадахгүй 1927 онд Өвөрмонголын намын удирдагч нарын зарим нь уван цаван Улаанбаатарт орж иржээ. Мэрсээ, Пу минтай, Буяннэмэх нар ч ирсэн. 1927 онд дахин Намын төв хорооны бүгд хурал хийж, төв хорооны бүрэлдэхүүнийг шинээр сонгожээ. Төв хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар Мэрсээ, орлогч даргаар Пу минтай, бас Өвөр зүгээс хэдэн хүн сонгогдсон. Нэрийг нь санахгүй байна. Ийнхүү холимог Өвөрмонголын ардын

³⁵ Дамбадорж Цэрэн-Очирын 1924-1928 онд МАХН-ын Төв Хорооны дарга байв.

³⁶ Очиров (Оширов) 1900 онд төрсөн. 1925 онд Өвөр Монгол дахь Коминтерний төлөөлөгч, Өвөр Монголын АХН-ын зохион байгуулагчдын нэг байв. 1927-1928 онд Трубочев, Райтер нарын хамтаар МАХН-ын зүүний хүчийг дэмжиж бүх талын дэмжлэг тусламж үзүүлэх зорилгоор Монголд байгуулагдсан КИГХ-ны бат бэх төлөөлөгчийн газрыг бүрдүүлж байв.

³⁷ Цэрэндонров Баяндай, Буянт (Цэрэндондов) (1894-?) Харчины дунд хошууны харъяат, 1924 онд Гоминданд элсэн орох гэсэн Дотоод Монголын залуучуудын хөдөлгөөнийг удирдсан бөгөөд Хаалганд Дотоод Монголын Гоминдан намыг зохион байгуулж, 1925-1927 онд намын даргаар ажилласан. Энэ нам 1925 оны аравдугаар сард Дотоод хязгаарын ардын хувьсгалт намтай нэгдэн Дотоод Монголын Ардын Хувьсгалт Нам болон байгуулагдахад тэрээр нэг удирдагч нь болжээ. 1925-1927 онд Хятадын хувьсгал дарагдасны дараа Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын дарга Цэрэндондов тэргүүтэй намын баруун жигүүр Чан-Кайши-н талд оржээ. Хожим 1945 онд Цэрэндондов Гоминданы Засгийн газрын дэргэдэх Монголын Хэрэг Эрхлэх Хорооны даргаар томилогдон ажиллаж байжээ.

хувьсгалт намын төв хороо сонгогдоод Улаанбаатарт орон байртай, хашаа контортой, аппараттай байсан юм. 1925 онд Чуулалт хаалгад болсон ӨМАХН-ын нэгдүгээр их хурлаас Пу минтайг Коминтернд илтгэл тавих төлөөлөгчөөр сонгосон байна. Тэр 1925 оны 11, 12-р сард Москвад очиж намайг Ленинградаас дуудсан. Пу минтай учир байдлаа хэлж би туслав. Тэгэхэд би жил болоогүй хүн чинь орос хэл юугаа мэдэхэв дээ. БНМАУ-ын элчин сайдын яамныхан, КУТВ-ынхон их тусалсан л даа. Пу минтай коминтерний хурал дээр Бухаринтай³⁸

уулзаж, түүнд ажлаа танилцуулж, Коминтерний тэргүүлэгч гишүүн Сен Катаяматай³⁹ уулзсан. Коминтернээс түүний илтгэлийг сонссоны дараа тэдэнд тусал гэж МАХН-д зөвлөсөн заалт өгсөн байх гэж санадаг. Коминтерний төлөөлөгч томилогдсон. Коминтерний төлөөлөгч манайхаас тусдаа байсан юм шүү. 1926-1927 оны үед Улаанбаатартаа цугларсан. Дахиж Цэрэндонров эргэж ирээгүй, тэр чигээрээ Чан-Кайшиг дагаад Тайвань руу явсан сураг дуулдсан. Энэ үед Өвөрмонголын намын байдал иймэрхүү байдалтай байсан юм.

1928 оны Баргын бослогын тухай

Би 1928 оны зун амралтаараа ирээд Халх голд ардын төлөөлөгчдийн хуралд Коминтерний төлөөлөгч Степановын⁴⁰ оруулагчаар явах болж 1928 оны 7 дугаар сарын сүүлээр бид гучаад хүн очиж билээ. Тэр хурал Хамар давааны ар тал Баянтохой гэдэг газар яг л миний төрсөн газар хуралдсан. Тэр хурлаар бэлтгэл байхгүй тул бослого гаргаж болохгүй хэмээн үзэж Монголд ч баруун, зүүн гээд тэмцэлдэж байсан болохоор хувьсгалын бэлтгэл ажил болгон ард түмний дунд суртал нэвтрүүлэг хийх шийдвэр гаргасан. Өлзий гуай тэр хуралд үг хэлж байв.

Хурал тарсны дараа бид Баргын гүнд орж суртал нэвтрүүлэг хийх боллоо. Би эхлээд долоо хоногоор Гүлхөхийн хошуунд явсан. Тэгэхэд хил хязгаар гэж байгаагүй шүү дээ. Морио унаад л гарч л байна, орж л байна. Тийм байсан юм. Тэнд би Пунцагдархан гэдэг айлд нууцаар байж, орой үдэш нь гишүүдтэй уулзаж, ухуулга таниулга хийж, бослого хөдөлгөөн гаргахад бэлэн байх хэрэгтэй гэдгийг таниулж байв.

Хувьсгал гарсны дараахан үргэлжлүүлээд Баргад хувьсгал хийх гэж 1922 онд Өлзий гуай тийшээ явсан гэнэ билээ. Өөрөө 500 винтов, хэдэн

³⁸ Бухарин Николай Иванович (1888-1938) - Оросын хувьсгалч, зөвлөлтийн улс төр, төр, намын зүтгэлтэн. 1920-иод оны үед БХК(б)Н болон Коминтерний удирдлагад байж, зарим асуудлаар Сталинтай санал зөрөлдсөний улмаас баруунтан хэмээх нэр зүүж, нам, төрийн удирдлагаас зайлуулагдаж, улмаар хэлмэгдсэн юм. Тэрбээр хамтралжуулын эсрэг байж, тариачдад баяжигтун хэмээх уриа дэвшүүлэн тавьж байсан билээ. Монгол үндэстэн нэгдмэл байх үзлийг дэмжиж байсан юм.

³⁹ Сен Катаяма (1859 - 1933) Япон болон олон улсын коммунист хөдөлгөөний зүтгэлтэн, сэтгүүлч, нийтлэлч. 1918 онд АНУ-д япон ажилчдын хамтаар коммунист бүлгэм байгуулж байсан, улмаар АНУ болон Мексикийн коммунист нам байгуулахад идэвхтэй оролцсон. 1921 оноос Зөвлөлт Орос Улсад амьдарч, Коминтерний Гүйцэтгэх Хорооны болон Гүйцэтгэх Хорооны Тэргүүлэгч гишүүнээр ажиллаж байсан. 1925 онд Монголд Коминтерний шугмаар ирсэн.

⁴⁰ Монголд оршин сууж байсан Орос иргэдийн зөвлөлийн намын үүрийн товчооны даргаар Степанов хэмээх хүн ажиллаж байсан байдаг.

пулемёт авч Баргад хувьсгал гаргахыг оролдсон боловч 1922 оны хавар их цас, зудтай, ард түмэн ч бослого хөдөлгөөн гаргах ямар ч бэлтгэлгүй байсан учраас Өлзий гуайн тэр ажил бүтэлгүй болжээ. Энэ туршлагаасаа үзэхэд ер нь сайн бэлтгэл хийх хэрэгтэй гэдэг нь харагдсан юм.

Энэ хурлаас Тамсагбулагт хувьсгалын төв гэдгийг байгуулж түүнд Өлзий гуай Пу минтай, Бошлой⁴¹ нар орсон. 2 дахь удаа Баргын дэвшилт ноёд сэхээтэн нарт тунхаг гаргасан. Энэ тунхагт, тусгаар тогтнох хөдөлгөөнийг өрнүүлснэ, Гамингийн дарлал тэсэхэд бэрх боллоо, Японы түрэмгийлэгчид төрөлх газар нутагт өнгөлзөж байна. Түүний эсрэг тэмцэл хийе гэдэг уриалга гаргасан юм.

Би дээрх тунхагийг аваад Хайлаар хот оров. Тэнд манай энд байсан улсууд олон байсан л даа. Эхлээд би Хасбаатарын буугаад, маргааш өглөө нь шууд Цэнд⁴² гүнийд очсон. Цэнд гүн

бол Их Монгол үзэлтэй. Автономит Монголын үед Гадаад Явдлын Яаманд байжээ. 1915 оны Хиагтын гурван улсын гэрээнд⁴³ оролцсон Монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцсон Манж, Монгол, Хятадтай эрдэмтэй ноён байсан юмаа. Энд байхдаа нууц товчоог хуучин хэллэгээс нь орчуулж монголчилсон юм гэдэг.

Цэнд гүнд бичгийг гардуулав. Удалгүй надад хүлээж байгаарай, өнөөдөр буцна шүү. Гадуур битгий яв! Болгоомжтой байгаарай гэсэн хариу өгөв. Тэгээд үдээс хойш явах боллоо гээд намайг дуудсан. Яваад очтол гадаа нь нэг хар суудлын машин байна. Энд машинд суу гэв. Тэр дотор гурван ноён байна. Нэг нь Баргын амбаны баруун журганы сайд Багабадь, нөгөө нь Гүлхөхийн хошууны дарга Чулуунгалдаа гэдэг хүн гурав дахь нь Зүүн яамны ерөнхий нарийн бичгийн дарга Дагаа хэмээх хүн байх юм. Ингээд суугаад явлаа. Тэр шөнөдөө

⁴¹ Бошлой Баргын хувьсгалч.

⁴² Цэнд гүн - Бавуудайн Цэнд (1875-1932) Өвөр Монголын Хөлөнбуйр аймагт Бавуудайн гуравдугаар хүү болон мэндэлсэн. Багаас гэрийн багшаар буюу бие даан хятад, монгол, манж бичгийг сайн эзэмшсэн тул Хөлөнбуйрын амбан яамнаа бичээч, тус яамны зүүн тэнхимийн даргаар ажиллаж байжээ. Улмаар Богд Хаант Монгол Улсын Засгийн газарт бичээчээс эхлээд яамны сайд болтлоо тушаал дэвшин ажиллаж байсан юм. Тэрбээр 1913 онд Долнуурын цэргийн хуаранд томилогдон байх үедээ Манлай ван Дамдинсүрэнгийн хамт Долнуурын байлдаанд оролцож гамин цэргийг цохиход идэвх зүтгэл гаргасан байна. Богд хаан түүний энэ гавьяа зүтгэлийг өндрөөр үнэлж “Бодлогот баатар гүн” хэмээх цол хүртээжээ. Бодлогот баатар гүн Цэнд ном зохиол уншиж судалдаг, бичгийн өндөр соёлтой, Монголын эртний хэл, хятад, манж хэлнээс гадна солоон, дагуур, орчоон хэлийг сайтар эзэмшсэн бөгөөд Монголын нууц товчоог монгол хэлээр орчуулсан билээ.

⁴³ Хиагтын гурван улсын гэрээ 1914 оны 8 сарын 26-наас 1915 оны 5 сарын 25 хүртэл есөн сарын турш Хиагт хотод Хятад, Орос, Монгол гурван улсын хооронд болсон хэлэлцээрийг хэлж байна. Тус хэлэлцээрт Монголын талаас Засгийн газрын бүрэн эрх барих төлөөлөгчдийн тэргүүнээр Дотоод яамны тэргүүн сайд, нэйс билигт, улсад туслагч гүн Да лам Дашжав (эхний 13 удаагийн уулзалтад оролцсон), түүний оронд Шүүх яамны дэд сайд жонон ван Ширнэндамдин ирсэн, Сангийн яамны тэргүүн сайд түшээт чин ван Г.Чагдаржав, зөвлөх нараар Шүүх яамны дэд сайд засагт чин ван Удай, Цэргийн яамны эрхлэн зөвлөх сайд жүн ван Манлайбаатар Ж.Дамдинсүрэн, Гадаад яамны дэд сайд хичээнгүй гүн Цэрэндорж, гүн Жигжиджав, орчуулагч түшмэлээр гүн Цэнд, Цэвээн Жамсран, Цогт Бадамжав, эх зохиох түшмэлээр гүн Насандэжид нар оролцсон юм. Монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Монголоос ирсэн Удай ван, Манлайбаатар Дамдинсүрэн, Цэнд, буриад угсааны Цэвээн Жамсран, Цогт Бадамжав нарыг багтаасан байдаг юм.

шинэ Баргын зүүн хошууны бүгдийн дарга Эрхэмбат⁴⁴, Укарыда⁴⁵ гээд их эрдэмтэй нөлөөтэй ноён байсан юм. Тэднийд очиж хоноход намайг тусгайд нь зуны байшинд оруулсан. Би шөнө нь жаахан айгаад буугаа сумлаад хонож билээ.

Маргааш нь бид цааш явж Буйрын ард талд, Булан дэрсний тэнд хил дээр хүрч очлоо. Хил дээр хэдэн ноёдоо орхиод, би харуулын цэргийн мориор цаг шахам яваад Тамсагт ирж хилийн харуулаас тэднийг хил гарах зөвшөөрөл авч, ноёдыг Пу минтай, Мэрсээ нарт тушаалаа. Ноёдыг Улаанбаатарт явуулсан. Тэд Улаанбаатарт ирж байгаа нь тэр шүү дээ. Би тэндээ л үлдсэн. Гэтэл тэр өдөртөө ч билүү маргааш нь ч билүү намайг бас дахиад яв гэлээ. Энэ удаа миний өссөн нутаг Мэхээрт рүү явж суртал нэвтрүүлэг хийх даалгавар өгчээ. Замдаа хоёр хонож хүрлээ. Тэнд миний ээж байсан юм. Тэнд би долоо хонохдоо хэд хэдэн удаа ухуулга яриа хийсэн. Энэ үед Мэрсээ Баргын нутагт ороод Гүлхөхийн хошууны цэргийг урвуулан 300-гаад хүнтэй отряд байгуулж бослого гаргахыг эрмэлзжээ. Хянганаас нааш Баргын хамгийн урд талд нууран дээгүүр гарсан нутгийн хил байдаг юм. Түүний наах нь байсан “Үнэр” гэдэг станцаар төмөр замыг нь таслаад нэг хэсгийг нь манжуураас зүүн тийш таслан Баргын нутгийн хэсэг газрыг тасалж аваад

засаг байгуулах гэсэн бодлоготой байсан боловч чадалгүй Мэрсээ ялагдаж Гүлхөхөд буцаж ирсэн байв. Намайг үүрэг даалгаврыг биелүүлээд Тамсагт ирэхэд Шинэ Барга хошууны төв Алтан Эмээлд суудаг хувьсгалчид хошуу ноён (Укарида) Чивсүнгээ хэмээх ноёноо баривчлаад Тамсагийн хувьсгалын төвд хүргүүлэн ирсэн байв. Тэд өөрсдөө 200-аад өрх айл БНМАУ-ын зүүн хязгаарын хил Гурванбаянд нүүгээд очсон байв. Ийм учраас тийшээ явах хэрэгтэй болж тэр эзэнгүй хүмүүст ямар нэг аргаар тусалж хил давуулах шаардлагатай гэсэн. Би явахаас өөр аргагүй боллоо. Намайг суудлын машинаар хүргэж өглөө. 200-аад км юм байна л даа. Тэр бол Манлай баатар Дамдинсүрэнгийн сум. Би Дансран гуайнд буулаа. Дансран гуай бол Манлай ван Дамдинсүрэнгийн хамт Автономитын үед Ховдод байлдаж явсан хүн. Тэнд харуулын цэргийн дарга хийж байв. Алтан Эмээлийн намын үүрийн дарга нь Гонгоржав хэмээх хүн байсан юм. Тэр бослогыг Гонгоржав удирдаагүй. Сумын дарга Шагдар гэж Манлай вангийн хамаатан байсан юм. Тэд нэг хошуу шахам айлаа цаад талаас нь мал хөсөгтэй нь нүүлгээд бүр хил дээр тулаад ирсэн. Хошуу цэрэг нь гэвэл 60-аад буутай цэрэгтэй байлаа. Тэндээс чадалтай нь манлай ван Дамдинсүрэнгийн хошууны сумангийн Мөр гэдэг цэргийн сумангийн дарга

⁴⁴ Эрхэмбат Рэгзэнчогнуугийн (1882-1951) 1896 оноос Хайлаарын монгол хошууны сургуульд суралцаж, монгол, манж хэл бичигт сурчээ. 1898 оноос сумын занги, 1920 оноос Шинэ барга зүүн гарын яамны бүгдийн дарга, хошууны дарга, 1936 оноос Манжийн Хянган хойт мужийн дарга, 1945 оноос Хөлөн-буйрын өөртөө засах мужийн засгийн ордонь тэргүүлэгч, 1949 оноос Хөлөнбуйр аймгийн дарга зэрэг алба хашиж байжээ. Тэрбээр 1926 онд хошуундаа анхны бага сургууль, 200 гаруй оточ бүхий Мамба дацан байгуулж байсан байна. Тэрбээр “Барга аймагтаны товч түүх”, “Шатрын ухаан”, “Амтат хурын дусал”, “Хураангуйлан зохиосон цэргийн арга бодлогын бичиг” зэрэг зохиол бичсэн байна.

⁴⁵ Хошууны тэргүүлэгч нь “үжэри даа” буюу “бүгдийн дарга” гэдэг байжээ.

хүн байв. Шагдар занги ч гэсэн чадалтай зоригтой Монголд орно л гэж хэлдэг хүн. Ингээд 2 өдөр цэргийн жагсаал сургууль хийж эмхлээ гэж би хэллээ. Тэгсэн ч би нааш Гурванбаян орж шар Цэнд гэдэг Дотоод Яамны төлөөлөгч байсан. Мөн тэрүүхэн ар талд хилийн харуул гэж байсан. Тэр нь Гүржав гэдэг хүн. Дэмидтэй хамт Тверь хотод морин цэргийн сургуульд байсан. Би мэдээгээ өглөө. Гэтэл нэг өглөө Хайлаараас нэг хүн давхиж ирж мэдээ өглөө. Тэр мэдээ нь 300-аад Гамин, 7 машинтай, Цэнд гэдэг Монгол ноёнттой, Монголруу оргосон айлуудыг буцаан авахаар мордлоо гэсэн байв. Ийм мэдээ аваад бид хуралдлаа. Би хувьсгалын төв штабын төлөөлөгч байсан болохоор тэд миний амыг л харж байлаа. Тэднийг Алтан Эмээлийн Оршоон голын гүүрэн дээр л угтан зогсоохоор боллоо. Орой гараад үүрээр яваад Алтан Эмээлд үдийн хавьд хүрч очлоо. Түрүүчийн тагнуул маань Алтан эмээлд юу ч байхгүй байна гэж ирсэн. Алтан Эмээл чинь их төв газар л даа. Оршоон голын том гүүр, гүүрийн хажуугаар айлын өвөлжөө зэрэг их юм байдаг. Бид яваад тулаад очсон чинь гүүр хардаг ганц манаач байна. Түүнээс асуусан чинь: аа, тэд өчигдөр харанхуй бүрэнхийд ирээд энд үдэлж хоол идээд баруун урагшаа явсан гэж хэллээ. 7 машин, 20-30-аад морин цэрэгтэй, машин дээрээ их буу ачсан, Цэнд гүн гэдэг нэг морин тэрэгтэй Монгол ноён дагасан, ийм улс явсан гэлээ. Бид ч болохоо байлаа гэж ярилцаад шөнөжин давхиж дүрвэсэн айлууд дээрээ ирлээ. Тэгтэл байхгүй, ирээгүй байв. Шөнөдөө хуралдлаа. Тэгтэл шөнө бас нэг мэдээ ирсэн. Адуун чулууны тэндэх нэг галдаа ноёныд

тэд нар байна. Нааш удахгүй хөдлөх гэж байгаа юм шиг байна гэсэн мэдээ ирсэн. Бидний зорилго бол бидний байсан газрын хавьд нэг нуур байсан, ямар нэртэй билээ дээ, тэр нууран дээр л бууна. Өөр устай газар байхгүй. Тэнд тэднийг зогсоож буцаая. Байлдахаас өөр аргагүй болов. Хоёр даваа даваад л хойшоо явахад айлууд байгаа шүү дээ. Бид тактикаа боловсрууллаа. Яг тэнд бууна. Ар талд нь нэг нуруу байдаг юм. Түүний цаана буугаад хүлээе. Ирэхтэй нь зэрэг л хоолыг нь идүүлэхгүй гал нээнэ шүү гэж тогтлоо. Би өөрсдийнхөндөө хэллээ. Тэд нар, 300-аад хүн бүрэн зэвсэгтэй, бид зөвхөн бирдан, цахиур буутай, 60-аад хүнтэй тэднийг тогтоохгүй болвол яах вэ? гэсэн. Тэгээд Мөртэй зөвлөлдөөд, тогтоож чадахгүй бол хойд талын өндөрлөг дээр Мөр хамаг цэргээ аваад гарна. Яг тэр үлдэж байгаа газартаа сайн морьтой, сайн буутай хэдэн хүн үлдээе. Гол хүчээ уулан дээр гаргаад, олон тийшээ зугатаая. Хойшоо айлууд руугаа зугатааж ерөөсөө болохгүй, харин баруун тийш 4-5 км-ийн цаана арзгар чулуутай хад бий. Тийшээ зугатаая. Тийшээ зугатах зам бол их намагтай машин явж чадахгүй, явган хүн ч явж чадахгүй.

Ийм учраас бидний хойноос хэдэн морьтой хүн л хөөхөөс биш. Та нар тэндээсээ галаад бай. Тийм учраас тэнд их цэрэг нь байна гэж тэд нар ойлгоно шүү дээ гэж тохиролцлоо. Тэгээд ийм байдалтай боллоо гэж Цэнд, Гүржав хоёртоо мэдээ хүргүүллээ. Тэгтэл удалгүй нөгөө гамингууд чинь гараад ирлээ. Орилолдсон, хашгиралдсан юмнууд л нуур тойроод ороод ирлээ. Тэгэхээр нь бид гал нээлээ. Бутраад сандраад л явчихлаа.

Явган цэргүүд нь биднийг бүслээд

өгсөөд ирсэн л дээ. Морин цэргүүд нь бидний араар бүслэх гэж явсан нь харин ч бидэнд ашигтай болсон. Юу юугүй л биднийг бүслээд гараад ирсэн л дээ. Тэгэхээр нь Мөр чи цэргээ аваад яв би үлдье, надтай хамт 5 хүн үлд гэлээ. Тэгтэл 2-хон хүн л үлдлээ. Бид 20 минут орчим галлалаа. Нөгөө 2 маань сайн винтовтой, би нэг маузертай. Тэгээд бид 3 нөгөө зугатаах гэсэн зүгрүүгээ л зугтаалаа. Араас хэдэн морьтой хүмүүс хөөлөө. Явган цэргүүд ч араас буудаж байв. Тэгтэл морин цэргүүд /Мөрийн цэргүүд/ гал нээгээд эхэлсэн. Би боорцгоо ганзаганаасаа авч талд хаясан. Гэтэл түрүүлж явсан хэд нь үзчихээд л мориноосоо буугаад овооролдоод харагдлаа. Би саад хийе гэж бодсон юм. Ингээд бид ч хүрэх газартаа хүрсэн. Мөрийн цэргүүд тэндээс амдаж буудаад, нөгөө биднийг хөөж явсан морьтой цэргүүд буцаад зугтаалаа. Би хоёр залуугаа “бидэнд туслаач” гэж Цэнд, Гүржав хоёр руу явуулж өөрөө нөгөө айлруугаа явлаа. Тэгтэл Гүржав ирээд айлд байсан зэвсэгтэй залуучуудыг бүгдийг нь аваад Мөртэй хамт урагшаа байлдахаар явсан

байлаа. Хойноос нь очсон чинь тэд нар гамингуудыг хөөж Хайлаар луу явсан байв. Тэр шөнөдөө бид манаж хоноод, маргааш нь хуралдаж, одоо л бид нар орохоос өөр аргагүй гээд Гүржавтайгаа уулзаж ярилцсан. Гүржав “одоо орцгоож болно, хамаагүй” гэсэн. Ингээд хүмүүсийг цуглуулаад 60 шахам бууг Гүржавт хураалгасан. Тэгээд Цэнд яваад ирсэн. Надад хандаж “Таныг дуудаж байна, та бушуухан явахгүй бол болохгүй” гэв. Би ч удалгүй Баянтүмэн рүү явж Гүржав, Мөр, Шагдар, Хайдав, Цэвээн, Иш лам гэх мэтийн үлдсэн хүмүүс хил давуулж айлуудаа оруулсан. Тэднээс саналыг нь асуухад нилээд айл цаанаа үлдээд буцсан гэнэ билээ. Тэд нь голдуу ноёдууд байсан. Тэр айлуудыг оруулаад Гурванзагал⁴⁶ суманд захируулсан. Би дуудагдаад Баянтүмэнд ирж, хэлтсийн дарга Цээрэгзэн гэдэг хүнтэй уулзаад Тамсаг руу явсан. Тэгтэл тэнд юу ч байхгүй нам, гүм болжээ. Айлуудыг хойноос ирсэн Гамингууд хөөгөөд аваад явчихсан. Бослого хөдөлгөөнд шууд оролцсон хүмүүс ганц нэгээрээ наашаа зугатааж орсон аж.⁴⁷

⁴⁶ Гурванзагал сумын үүсэл нь Богд хааны зарлигаар Манлай баатар ван Жамсрангийн Дамдинсүрэнгийн мэдэлд 1917 онд Сэцэн хан аймгийн Сансрайдоржийн хошууны Зээрэнт, Моончиг, Ухаа-Овоот зэрэг харуулын нутгийг олгож, нүүж ирсэн барга ардуудын захирсан сумыг хошуу болгож, 1918 онд тус хошуунд Мөнхтолгой, Хөвөлзөх хоёр харуулын нутгийг нэмэн олгосноор тавигджээ. Манлайбаатар Дамдинсүрэнгийн хошууны хүн ам нь Нийслэл Хүрээнд байсан Барга, Өвөр Монгол цэргүүд болон 1917 оны хавар нүүж ирсэн Манлайбаатарын гэр бүл, ах дүү, албат ардаас бүрдэж байжээ. Тус хошуу 1918 оны байдлаар 87 өрх, 340 хүн амтай, 1922 оны байдлаар 62 өрх, 578 хүн амтай байжээ. Манлайбаатарын хошуу 1923 оноос Хан Хэнтий уулын аймгийн Амгалан хан уулын хошуу гэсэн нэртэй болж, 1927 онд Улз голын хошуунаас салж, газар усныхаа нэрээр Гурванзагал гэсэн нэртэй болжээ. 1931 оны БНМАУ-ын засаг, захиргааны өөрчлөлтөөр Дорнод аймгийн Гурванзагал сум болон зохион байгуулагдсан байна.

⁴⁷ 1928 оны Баргын энэ хувьсгалыг Коминтерн, МАХН-аас турхирч, шууд оролцоотой зохион байгуулсан боловч гадаадын хэвлэлд Баргын бослогын тухай “ЗХУ хувьсгалыг экспортолж байна” гэсэн буруушаасан мэдээ гарч эхлэнгүүт Зөвлөлтийн зүгээс Баргын талаар баримталсан бодлогоо өөрчлөхөд хүрчээ. Иймээс БХК(б)Н-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1928 оны 8 сарын 10-ны өдрийн 38 дугаар хуралдаанаас Баргын бослоготой холбогдуулан шийдвэр гаргаж, “Бослогын тухай хэвлэлд зориулсан мэдээ зохиох”, “Өвөр Монголд ажиллаж байсан Коминтерний төлөөлөгчийн үйл ажиллагааг зогсоож, яаралтай шалгах, шаардлагатай бол

Би буцаж Баянтүмэнг дайраад Улаанбаатарт ирээд 10-аад хоноод л хойшоо сургуульдаа явсан. Баргын Хувьсгалт Намын Төв Хорооноос тэнд очсон улсуудаас Пу минтай, Өлзий гуай нар наашаа буцаж ирсэн. Мэрсээ 200-300 цэрэгтэй бослого гаргах гэж цаашаа ороод “Үнэр” станцаар тасалж, Хайлаарыг эзэлж авах гээд чадаагүй, бут цохигдоод юу ч үгүй хоцорсон. Тэр үед Мэрсээ нааш орж ирж чадаагүй, яагаад гэвэл, баруунтан болоод буцсан хүн. Профинтерний⁴⁸ хуралд ч явж байсан. Энд намын VII хурал⁴⁹ болох гэж байсан үе шүү дээ. Ийм учраас Мэрсээ ирэх боломжгүй болж, тэндээ учраа олох арга хайжээ. Тэгээд “Жанжин сүмийн тунхаг” гэж нэг жижигхэн Тунхаг гаргасан юм гэнэ билээ. Мэрсээгийн бослогод

оролцсон 300 цэрэг нь ч тараад алга болж, 40-50 цэрэгтэй л үлдсэн. Буйр нуураас зүүн тийш орших Гүлхөхийн хошууны нутаг Жанжин сүм дээр Мэрсээ, Жан Золины төлөөлөгчтэй болзсон. Тэд нар Мэрсээг өөрийн талд татаж авах гэж оролдсон л доо. Мэрсээ тэдэнд хэдэн зүйлийн шаардлага тавьсан. Баргыг автономит болго, дотоод эрхэнд битгий халд, Монголчуудаа Баргачууд өөрсдөө захирна. Өөрийнхөө нутгийн түүхий эд, эдийн засгаа өөрсдөө мэднэ. Хэрэв энэ хэдэн шаардлагыг биелүүлэхгүй бол би байн, байн бослого гаргахад бэлэн гэсэн байна. Тунхагийг Жан Золиний хүү хүлээн авсан. Ер нь Жан Золиныхан Мэрсээгийн бослого гаргахыг дэмжсэн юм шүү. Яагаад гэвэл Жан Золин бол өөрөө Японы

баривчлах”, “Бослогыг хамгийн уршиг багатайгаар намжаах арга хэмжээ авах”-аар тогтоож байжээ. Эл асуудлыг Карахан танилцуулжээ. Шийдвэрийн доод талд Төв хорооны нарийн бичгийн дарга В.Молотов гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

⁴⁸ Профинтерн буюу Үйлдвэрчний эвлэлүүдийн улаан интернационал гэж 1921-1937 онд оршин байсан олон улсын хувьсгалт үйлдвэрчний эвлэлүүдийг нэрлэж байжээ. Профинтерн буюу олон улсын үйлдвэрчний эвлэл хэмээх байгууллага нь 1921 оны 7 сарын 3-нд Москва хотноо байгуулагджээ. Профинтерний зорилго нь нь коммунист үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд болон коммунист байгууллагуудын хоорондын үйл ажиллагааг зохицуулахад оршиж байв.

⁴⁹ Намын VII хурал - 1928 оны намар БХК(б)Н болон Коминтерноос томилогдсон Б.Шмераль тэргүүтэй төлөөлөгчдийн шууд зохион байгуулалт дор болсон МАХН-ын 7 дугаар их хурлыг хэлжээ. Шмералаас гадна МАХН-ын VII их хуралд Коминтерний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд М.Амгаев, Америкийн коммунист, Профинтерний төлөөлөгч Вильям Макдональд, КИМ-ийн төлөөлөгч Вартанин нар багтаж байсан ба дээр нь нарийн бичгийн дарга, орчуулагч нар дагалдаж иржээ. Тус хурлаас Монгол үндэсний ардчилсан үзэл баримтлагчдыг баруунтан хэмээн буруушааж, нам, төрийн удирдлагаас зайлуулж, засгийн эрхэнд хөдөөнийхэн буюу КУТВ төгссөн зүүнтнийхийг хүчээр тавьсан юм. Энэ бол төрийн эргэлт болсон бөгөөд АНУ-ын эрдэмтэн Р.Рупен бээр хувьсгал энэ их хурлаас монголд эхэлсэн хэмээн дүгнэсэн байдаг. “Хөдөөнийхөн”, МАХН дахь зүүний чиг шугамыг баримтлагчдыг ийнхүү нэрлэж байв. “Хөдөөнийхөн” Монгол дахь барууны аюулын тухай ярьж, улмаар коминтерны төлөөлөгчдөөс дэмжлэг авч, 1928 онд хуралдсан МАХН-ын 7 дугаар их хурлаар Коминтерны төлөөлөгчдийн шууд оролцоотойгоор засгийн эрхийг авсан болно. “Хөдөөнийхний” төлөөлөгчид нь Дорлигжав, Ө.Бадрах нар байв. Бадрах Өлзийтийн, Дөрвөдийн Үнэн Зоригт аймгийн Зоригт ханы хошуу буюу одоогийн Увс аймгийн Давст сумын харъяат (1895-1941). 1924 оноос Сангийн яамны сайд, 1928 оноос МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга, 1928 оноос Эрүүлийг хамгаалах яамны сайдаар ажиллаж байжээ. 1928 оны МАХН-ын 7 дугаар их хурлын өмнө Намын зүүн ангийн эрмэлзэх санал хэмээх баримт бичгийг боловсруулалцаж байсан. 1937 онд улс төрийн хилс хэрэгт баривчлагдаж, улмаар 1941 оны 7 дугаар сард ЗХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн коллегийн шийдвэрээр цаазлагдсан байна. Хожим цагаатгагдсан байна.

талын хүн л дээ. Гэхдээ яг л Квантуны арми байгуулагдаж, Манжуурыг эзэлж авахад нь Жан Золин их дургүйцсэн. Ингээд Жан Золин өөрөө Японд алуулсан. Яагаад алуулсан бэ? Гэвэл, Жан Золины хүү Манжуурт 300-аад мянган цэрэгтэй байсан. Японы квантуны арми байгуулагдахад тэд нар эсэргүүцэх гэж их оролдож байсан. Тэхдээ Японы квантуны арми чинь сая цэрэгтэй газар шүү дээ. Ингэхээр яаж дийлэх вэ? дээ. Хэсэг, хэсэг газраа алдаад л байсан л даа. Ийм учраас Жан Золин, Чан Кайшитай нэгдсэн фронт байгуулах гэж олон удаа оролдсон. Чан Кайши үүнийг зөвшөөрөөгүй юм. Мэрсээ бол 1925 онд Баргын ард түмэнд хандан Японыг эсэргүүцсэн тунхаг гаргаж байсан, Японыг эсэргүүцэгч хүн байлаа. Жан Золины хүү Мэрсээд Монголын асуудлыг эрхэлсэн зөвлөх, өөрийн туслах Шаулин нарыг төлөөлөгчөөр илгээж Жанжин сүмд хэлэлцээ хийснээр Мэрсээ Жан Золинд зэвсгээ хураалган бууж өгчээ. Мэрсээгийн 5 зүйлийн шаардлагыг биелүүлэх ёстой боллоо. Ингэж Мэрсээ Мүгдэн орж бослогод оролцсон хүмүүсийг шийтгэхгүй байх, 200 хүнтэй багшийн сургууль байгуулж өгөх, Баргад автономит эрх олгох, Монголчуудаа өөрсдөө захирна гэсэн шаардлагыг хангуулжээ. Тэнд Мэрсээ 2-3 жил суужээ. Гэтэл

Япончууд цаанаас нь эзэлсээр байлаа. Одоо Мэрсээ хаачих вэ? Жан Золин яагаад ч сая цэрэгтэй Японы армийг зогсоож чадахгүй болох нь тодорхой байв. Мэрсээ Манжуурт байх газаргүй боллоо. Ийм учраас ЗХУ-д очхоор шийдсэн байна л даа. Манжуур хотод суугаа Зөвлөлтийн консулын газар тэр очиж, Зөвлөлтөд орогнуулахыг гуйжээ. Түүнийг дагуулж очсон 2 хүнийг консулын газар оруулсангүй хөөгөөд явуулжээ. Сүүлд нь сонсвол Мэрсээг Зөвлөлт рүү явуулсан сурагтай байдаг юм. Бодвол тэгээд л дууссан байх. 1934-1935 оны үед шүү дээ. 1928 онд өвөл Улаанбаатарт ӨМАХН-ын онц их хурал хуралдаж Баргын бослогын тухай асуудлыг авч хэлэлцсэн. Энэ бослого бол зөвшөөрөлгүй гарсан, хувсгалын эсэргүү бослого гэж үнэллээ. Мэрсээ бол энэ бослогын удирдагч учраас хувсгалын эсэргүү мөн гэж хурлаас дүгнэжээ. Энэ их хурлаар ӨМАХН-ын шинэ нарийн бичгийн даргаар нь Пу минтайг сонгосон. Би дараа жил нь төгсөж ирээд Ардын гэгээрлийн яаманд ажиллаж эхэлсэн энэ үеэс би Баргын хувьсгалт намын ажилд оролцоогүй. Ер нь холбоо байхгүй болсон. Энд Барга Өвөрмонголтой ямар ч холбоогүй тасархай Төв Хороо байгуулсан л даа.⁵⁰ Энэ Төв Хороог 1935-1936 оны үед ЗХУ-аас сургуульд оруулна гэж

⁵⁰ КИГХ-ны Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газрын 1929 оны хоёрдугаар сарын 22-ны хуралдаан дээр П.Гэндэн илтгэл тавихдаа: Одоо Дотоод Монголын ардын хувьсгалт намын ажлын тухай. Урьд МАХН-ын Төв Хороо болон Дорнод Монголын ардын хувьсгалт намын хэд хэдэн удирдагчид урван тэрсэлсэн учраас энэ холбоо суларсан юм. Ер нь Дотоод Монголын Ардын Хувьсгалт нам одоо төдий л буурьтай биш, нягтрал, зохион байгуулалтын хувьд төдий л сайн биш, төдийн л буурьтай сайн ажиллаж чаддаггүй байгууллага болж байна. Тус нам ийм л байдалтай байна. Би бол Дотоод Монголын Ардын Хувьсгалт намын ажлыг их суларсан гэж хэлэх байна. Одоо Улаанбаатарт 3 хүнээр удирдуулсан Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын Төв Хороо бий. Энэ нөхөд хөрөнгө мөнгөөр гачигдаж байна. Тэдэнд манай Төв Хороо зарим талаар тусалдаг боловч Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны өмнө одоо орон нутагт ажил зохиох, өөрийн төлөөлөгчдийг орон нутагруу илгээх зорилт тулгарч байна. Үүнд манай намын зүгээс тодорхой хэмжээгээр туслах хэрэгтэй юм. Бид ямар хэмжээгээр туслах хэрэгтэй

дуудсан гэнэ билээ. Пу минтай энэ тэр л явсан тэгээд тэр чигээрээ алга

болсон. Бодвол Сталины гарт үрэгдсэн байх. Ийм л юм болсон.

Хилс хэрэгт баривчлагдан шоронд хоригдсон тухай

Би 1938 оны 12 дугаар сард баригдаж шоронд орсон. Тэр үеийн харсан, үзсэн баримтаа яримаар санагддаг юм. Одоогийн сонинд гарч байгаа зүйл бол хүн бүр л баригдсан, тамлуулсан, хэрэг хүлээгээд 10 жил авсан гээд л голдуу бичиж байна. Миний бодоход энэ бас учир дутагдалтай санагддаг. Олон арван мянган хүмүүс баригдсан шүү дээ. Тэхдээ бүгдийг нь алаагүй. Би баригдсанаас хойш 7-8 сар мөрдөнд сууж тамлуулаад дараа нь орчуулагчийн группт ажилласан. Дараа нь Төв засанд шилжиж эмнэлэгт 3 жил ажилласан юм. Миний хамт хоригдсон хоригдлууд, хоригдлууд гэдэг нь манай намын гишүүд, цэргийн дарга нар, алба хаагчид шүү дээ. Тэд нар яаж, ямар байдалтай байсан бэ? Жишээлбэл төв засанд 2000-3000 хүн байсан. Би энэ бүгдийн тухай л ярихыг бодсон юм. Би 1938 оны 12 сард баривчлагдаад 7 сар орчим тамлагдаад бүх бие хавантай босож ч чадахгүй, хэвтэж ч чадахгүй үхэхийн даваан дээр байтал нэг өдөр 1939 оны 6 сарын орчим байх хэлтсийн

сургагч Авилов гэдэг хүн дуудлаа. “Тэр хүн чамаар ажил хийлгэнэ. Хийнэ биз” гэхэд нь би тэгэлгүй яахав гэж хариулсан. Энд нэг зүйлийг нэмж хэлье гэж бодож байна. Миний газарт хэцүү явдал тохиолдож хүүхэд минь шатаж үхэж, гэр бүл минь ажилгүй хаягдсан байв. Тэр минь айлаар зарцлагдан хүний хиртэй хувцас угаах, янз бүрийн л юм хийж явсан байх л даа. Тэр үед чинь эсэргүүгийн гэр бүл гээд ажлаас нь хөөдөг байсан шүү дээ. Ар гэрийн энэ байдал надад цаазлагдсанаас илүү хүнд байсан. Ер нь үхчихсэн нь дээр юм шиг надад санагдаж байсан ч шоронд хамт байсан нөхөд минь намайг ятгаж их л тус болсон л доо. Гэр бүлийн тухайд юу тохиолдсоныг яриад яах вэ? надтай адилхан зовлон тохиолдсон л доо түүнд. Тэгээд салаад, орхиод явсан л даа намайг.

1939 оны зун 6 сарын үед намайг хорьж байсан камераас гаргаад хөтлөн авчирч, Дотоод яамны барьсан холбоо 2 гэрт орууллаа. Тэгтэл тэнд таньдаг улсууд хэд хэд байв. Хэн, хэн байсан бэ? гэвэл Гэгээрлийн яамны

юм. Бид ямар хэмжээгээр туслах ёстой вэ гэдгийн тухайд Коминтерний зүгээс заавар заалт өгөхийг хүсэж байна. Бас Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын ажлыг зохих хэмжээнд хүргэхийн тулд Коминтерн анхаарал тавих хэрэгтэй юм хэмээн өгүүлжээ. Тус хуралд КИГХ-ны гишүүн Миф дэмжиж үг хэлсэн буй. Миф Павел Александрович (жинхэнэ нэр нь Фортус Михиал Александрович) (1901-1938). 1921-1923 онд КУТК-ын ажилтан, 1925-1927 онд КУТК-ын орлогч захирал 1927-1928 онд мөн сургуулийн ректор байсан. 1928-1930 онд КИГХ-ны Алс Дорнодын хэлтсийн орлогч эрхлэгч, 1936 оны тавдугаар сараас 1937 оны нэгдүгээр сар хүртэл КУТК-ын ректор, дараа нь үндэстэн ба Колонийн асуудал судлах институтын захирал байв. Хэлмэгдсэн, хожим цагаатгагдсан.

сайд байсан Бадамын Дугаржав⁵¹, Дүгэрсүрэн⁵⁶ гэдэг багш, цэргийн Бямбын Ринчин⁵², Төв хорооны нарийн яамны орчуулагч Эрхэев Самбуу⁵⁷ бичгийн дарга байсан Шижээ⁵³, нар байв. Дээрээс нь нэмээд би орлоо. Наваан-Юндэн⁵⁴, Чимэддоржийн Бид нарт тусгайлан хоол өгдөг, түлэх Дашням⁵⁵ /багш, сэтгүүлч хүн байсан/. түлээтэй нилээд чөлөөтэй байв.

⁵¹ Дугаржав Бадамын (1888-1941) 1924-1929 онд МАХН-ын Төв Хорооны суртлын хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байв. 1924-1940 онуудад Гэгээрлийн яамны сайд, Статистикийн удирдах газрын дарга, худалдааны байгууллагад тасгийн эрхлэгч, Улсын банкны эрхлэгч, Улсын банкны мэргэжилтэн, ЗСБНХУ дахь БНМАУ-ын элчин төлөөлөгчийн газрын орчуулагч, Санхүүгийн сургуулийн захирлаар сонгогдож байв. 1940 онд хэлмэгдсэн. 1957 онд цагаатгагдсан.

⁵² Еншөөбү овогт Бямбын Ринчен (1905-1977) XX зууны манлай монголч эрдэмтэн байв. Монголын шинжлэх ухааны зүтгэлтэн, зохиолч, орчуулагч, соён гэгээрүүлэгч. 1961 онд БНМАУ-ын ШУА-ийн жинхэнэ гишүүн, академичаар сонгогдсон. 1914-1920 онд Алексеевский сургуульд сурсан. 1923-1924 онд Бямбын Ринчин Верхнеудинск буюу өнөөгийн Улаан-Уд хотын багшийн техникумд сураад 1924 онд хэсэг монгол оюутнуудын хамт Ленинградд үргэлжлүүлэн суралцахаар явж Дорно дахины хэлний ангид элсэн сурсан байна. 1927 онд Сургуулиа төгсөөд Улаанбаатарт ирж, Судар бичгийн хүрээлэнд ажиллажээ. 1937 онд тухайн үеийн нийгмийг шүүмжилсэн хэргээр баригдан шоронд хоригдож байжээ. 1942 онд суллагдаж МАХН-ын Төв хорооны шийдвэрээр “Үнэн” сонины газарт заагдан 1958 он хүртэл арван зургаан жил ажилласан байна. 1956 онд “Монгол хэлнүүдийн харьцуулсан түүхэн хэлний зүй” бүтээл туурвижээ.

⁵³ Шижээ Золбингийн (1901-1941) 1921 он хүртэл өөрийн хошуу ноён Сумьяа бэйсийн бичиг хэргийн ажилд тусалж байжээ. 1921 онд Ардын журамт цэрэгт элссэн. 1924-1928 онд Москвад КУТВ-д суралцаж төгссөн. 1928 онд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлийн нарийн бичгийн дарга, 1929 оноос Дотоодыг хамгаалах газрын дарга, 1930-1932 онд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж, 1930 оны 4 сараас Монгол банкны орлогч даргын ажлыг хавсарч байжээ. Тэрээр МАХН-ын VII, VIII их хурлаас Намын Төв Хорооны гишүүн, тэргүүлэгч гишүүнээр сонгогдож байв. 1937 онд улс төрийн хилс хэргээр баривчлагдаж, 1941 онд хэлмэгдсэн. 1963 онд цагаатгасан.

⁵⁴ Чингис хааны алтан ураг, Хараагийн баатар ван Насан-Очирын Наваан-Юндэн (1908-1985) 1908 онд Түшээт хан аймаг, одоогийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт Насан-Очирын хүү болон мэндэлжээ. 1926 оноос Германд сурсан анхны 35 оюутны нэгэн билээ. 1985 он хүртэл монгол хаадын угсааны хамгийн сүүлд амьд сэрүүн үлдсэн ноён гаралтай хүн байв. 1926-1929 онд анхны дунд сургуулиас шалгарсан 35 сурагч Герман, Франц улсад сурахаар гэргий Хаалайн хамт явж Герман улсын Lichterfelde дунд сургуульд сурсан. 1929 оны намар Монголдоо дуудагдан ирэв. 1930-1932 онд Ардыг гэгээрүүлэх яаманд ном хэвлэл, латин үсгийн зөвлөлд үсэг хянагчийн ажил хийж байжээ. 1932 оноос ЗХУ-н Омск хотын анагаах ухааны дээд сургуульд эхнэр Хаалайн хамт суралцаж байхад нь 1933 онд Оросоос эргүүлэн дууджээ. Наваан-Юндэн улсын төв театрт жүжигчинээр ажиллаж, уран зохиолчдын анхны уран сайхны радио үдэшлэг болж, Монголд радио нэвтэрчээ. Учиртай гурван толгой дуурийн анхны Юндэнгийн дүрд Н.Наваан-Юндэн, Дэвээ Нансалмаад тоглохоор болсон ч Дэвээг эсэргүү Жамьянжавийн эхнэр хэмээн болиулжээ. 1934 онд ахин Омск хотыг зорих завшаан олов. 1938 онд хилс хэрэгт баривчлагдан шоронд сууж байхдаа Большевик намын түүх зэрэг номыг орос хэлнээс монгол хэлрүү хөрвүүлсэн байдаг. 1950 оны 3 сард 12 жил шоронд суугаад гарч ирээд улаан эрдэмтэн хочит Бархасын Банзрагчийн гэрт очжээ. 1965 онд Австри улсад очиж худалдааны гэрээ хийж, 1966-1969 онд эрдэм чадлынхаа хүчээр ардчилсан Герман, Унгар улсад элчин сайдын яаманд ажилтан болж, Монгол улсын их сургуульд багшилан олон шавьтай болжээ.

⁵⁵ Дашням нэрт зохиолч, судлаач, шүүмжлэгч, сэтгүүлч байжээ. 1928 онд Багшийн сургууль төгсөөд “Залуучуудын Үнэн” сонинд сурвалжлагчаар ажиллаж байхдаа сэтгүүл зүйд шүүмж хэмээх бичлэгийн шинэ өнгө аясыг оруулжээ. 1938 онд хилс хэрэгт баривчлагдан арван жилийн хорих ялаар шийтгэгээд өвчний улмаас 1940 онд шоронд таалал болжээ.

⁵⁶ Дүгэрсүрэн багш байжээ.

⁵⁷ Самбуу Цэргийн яаманд орчуулагч байсан.

Тэгэхдээ орчуулагчийн групп гэдгийг байгуулсан юм байв. Юу орчуулсан бэ? Гэвэл, хамгийн түрүүнд “ЗХУКН-ын товч түүх”-ийг орчуулах ёстой байв. Түүнийг бид яаралтай орчуулсан 2 сар ч болоогүй, сар гаруй хугацаанд л орчуулсан. Гол ажлыг Ринчин, Дугаржав гуай хоёр л хийсэн. Түүний дараа биднийг тараалгүй Дотоод яамны янз бүрийн /дэлхийн I дайн зэрэгт явж байсан/ гадаадын тагнуул зэргийн бичсэн зүйлүүд, цэргийн дүрэм, бусад албан газрын тогтмол хэвлэл зэргийг орчуулж байв. Сургуулийн сурагчдын сонирхон үзэх ном хоёр, гурвыг орчуулсан. Ингээд 1940 оны зун хүртэл энэ ажлыг хийв. Биднийг дуудахаа ч больсон. Биднийг Кизиков, /Дотоод яамны зөвлөх/ Авилов хоёрын мэдэлд байсан болохоор Дорж энэ тэр яах ч үгүй. Бид ч бас сүүтэй цай, сонин сэтгүүл шаарддаг ийм болсон байв. Энэ хооронд бидний дотор нилээд өөрчлөлт гарсан. Хамгийн түрүүн Чимэддоржийн Дашням, Дүгэрсүрэн багш хоёр маань уушгины сүрьеэгээр нас барсан.

1940 оны 3-р сард нэг шөнө Доржиев гэдэг халимаг ирээд Шижээг аваад явсан. Хаашаа аваачсан юм бүү мэд! Оронд нь Гүрийн Дашням гэж цэргийн дарга ирсэн. Тэр хүн ч бидэнтэй удаагүй хэдэн сар л болсон байх. 1940 оны 6 сард миний хэргийг таслалгүй төв засанд шилжүүлсэн. Тэнд зунжин байгаад намар 9 дүгээр сарын хавьд намайг дуудсан. Тэхдээ мөрдөн рүү дуудаагүй гадаах нэг хоосон гэрт оруулсан юм.

Тэнд хоёр, гурав хоног болоод би тэсэлгүй намайг яах гэж байгаа юм

бэ? Бушуу нэг тийш болгож өгөөч гэж шаардсан л даа.

Тэгтэл нэг арай гэж дуудлаа. Хуучин Дотоод яамны зөвлөх Кизиков⁵⁸ гэж нэг халимаг байсан юм.

Очсон чинь Кизиков биш, түүний оронд 60-аад настай орос хүн сууж байна. Намайг суу гэлээ. Та Эрдэмбилэг үү? гэв. Тийм гэлээ. Тэгтэл Орос: Би Мальцев⁵⁹ гэдэг хүн. Саяхан энд зөвлөхөөр ирсэн. Чиний хэрэг, мэдүүлэгтэй чинь танилцлаа.

Чи Барга хүн үү? -Тийм гэлээ. Чи ЗХУ-д байсан уу? Тэнд сурч байсан уу? Тэнд коммунист намд байсан уу? Энэ бүхэн чинь зөв бичигдсэн биз гэж асуулаа. Зөвөө бүгд үнэн бичигдсэн гэв. Гэтэл тэр хүн би чамас ганц юм асууя. Чи Баргад байхдаа гадаадын ямар нэгэн тагнуулын газартай холбоотой байсан уу? -Үгүй, тийм юм ерөөсөө байгаагүй. Би 18 насандаа намын анхдугаар сургульд томилогдож ирсэн хүн. Түүнээс түрүүн тэндээ намын ажил хийж байсан. Заа тэгвэл ойлголоо, яв гэлээ. Тэгээд л хонх дарсны дараа хүн орж ирээд намайг аваад гэрт минь аваачаад л хаячихлаа. 3 хоносны дараа л болов уу, нэг орой комендант дуудаж байна гэлээ. Очлоо. Конттортоо оруулаад суу гээд суулгасны дараа “на” гээд л нэг бичиг гаргаж өглөө. Тэр бичгийг үзсэн чинь тусгай комиссын миний нэр дээр “10 жилээр ял шийтгэсүгэй” гэсэн тогтоол байна. Уншсан бол гарын үсэг зур гэхэд нь би “ямар хэргээр шийтгэж байгаа юм бэ? Гэж асуухад би яаж мэдэх юм бэ? Миний мэдэхгүй гэдгийг чи өөрөө мэдэж байгаа шүү дээ гэж хэллээ. Би дуугүй гарлаа. Тэндээс

⁵⁸ Кизиков - БНМАУ-ын Дотоод явдлын яаманд зөвлөх байв.

⁵⁹ Мальцев ЗСБНХУ-аас БНМАУ-д сууж байсан Бүрэн эрт төлөөлөгчийн газарт зөвлөхөөр ажиллаж байжээ.

намайг туугаад л төв засанд аваачиж өгсөн юм.

Ингээд Төв засанд би 3 жил хоригдож, Дараа нь хөдөөгийн хорих лагериудаар дамжин дан эмнэлэгийн ажил хийж явсан. Би юуны урд Төв засангийн хоригдлуудын байдлыг товч ярихыг хүссэн юм. Тэр үед хилсээр баривчлагдсан манай нам, эвлэлийн алба хаагчид, залуучууд зүгээр нэг хорионд байгаад л юу ч хийдэггүй байсан гэдэг бол буруу болно. Манайд том, том үйлдвэр ялангуяа барилга, хөдөө аж ахуй, сангийн аж ахуйг хоригдлууд барьж өгсөн. Би төв засангийн тухай ярьж л даа. II тусгай эмнэлэгийн урд талд, замын урд, арьс өнгөний больниц бий шүү дээ. Тэнд чинь засан хүмүүжүүлэх байсан юм. Дарга нь Чойжамц гэж нэг харгис хүн байсан. Тэнд хэд хэдэн том үйлдвэр гэх мэт. Ялангуяа 1940-1941 оноос эхлээд фронтын бэлгийн зүйлүүд, дээл хувцас зэргийг тэнд үйлдвэрлэж байсан. Үнэндээ тэнд байсан хоригдлуудын гараар л бүх ажил бүтсэн юмаа. Би хэдийгээр яг үйлдвэр дээр ажиллаагүй, эмнэлэг дээр ажиллаж байсан боловч өөрийн нүдээр үзэж гурван жил хутгалдаж өнгөрөөсөн хүн. Эд нар /хоригдлууд/ ЗХУ-ын эх орны дайны хүнд хэцүү үед үнэхээр өөрийн хүч чадлаа гаргаж, түүнд туслах, ялуулахын төлөө баатарлаг хөдөлмөрлөж байсан юм. Жишээлбэл 30000 дээл, 30000 хантааз хийх даалгавар өгөхөд хоригдлууд богино хугацааны дотор хийж дуусгасан билээ. Энэ бол 1941-1942 оны үе шүү дээ. Жишээлбэл Цогзана⁶⁰ байна.

Хар нүдэн Сандуйжав⁶¹ төв засанд тоо бүртгэгч хийж байсан хүн одоо амьд байгаа. Төмөр замд байдаг юм. Тэр хүн хоригдлуудын хийж байсан дээл, хантааз, бээлий зэрэг бэлгийн бүтээгдэхүүний тоо хэмжээг сайн мэдэх байх.

Халх голын баатар, эх оронч Жүгдэрнамжил⁶² тэнд байсан. Ер нь хоригдлууд ёстой эх оронч хөдөлгөөн гаргасан юм шүү. Тэр ч байтугай 1945 оны Халх голын үед (Дэлхийн хоёр дугаар дайныг андуурч хэлжээ. О.Б) хэсэг цэргийн дарга нар Зүүн Хараагаас /20-иод хүн/ фронтод мордоно гээд зөвшөөрөлгүй оргосон юм. Гүйцэтгэх хэлтсийн дарга нь хэн билээ? Мартчихаж. Тэр дуудаад байцаана гэхэд нь урдаас нь хараагаад “эх орноо хамгаалж цэрэгт явах гэж байна” чи тэднийг хайрлаж байгаа юм уу? Хамгаалж байгаа юм уу” гэж урдаас нь загнаад, тэгээд замын машинд хорь, гучуулаа сууж цэргийн яаман дээр ирсэн. Тэднийг яг л хуучны тушаалаар нь, цалин, албыг нь өгөөд фронтод явуулсан. Тэд нар чинь дайнд яваад ялалт байгуулаад ирсэн улс шүү дээ. Жишээ нь Цогт-Заныг аваад үзье л дээ. Энэ хүн бол тэргүүний ажилчин. Өдөр шөнийн 24 цагт 30 нэхий дээл оёх үүрэг аваад маргааш нь цусаар шээлээ гэж надад амбулаторид ирж үзүүлж байсан юм. За мөн зохиолч Ц.Дамдинсүрэн /сэтгүүлч/ байна. Энэ хүн бас тэнд ажиллаж байсан. Эд нар одоо амьд байгаа шүү дээ. Эдгээр хүмүүсийг нэрлэж болох байна. Шоронд орсон хэлмэгдсэн гээд гутарч ажлаас хойш

⁶⁰ Цогзана намтарын мэдээ тодорхойгүй.

⁶¹ Сандуйжав намтарын мэдээ тодорхойгүй.

⁶² Жүгдэрнамжил Чоймборын Дорнотын хязгаарт пулемёт сумангийн дарга хийж байсан, 1938 оны 7 сараас 1939 оны 7 сард Эрүүлийг Хамгаалахын сайдаар ажиллаж байжээ.

суусан хүн байхгүй. Тэр офецерууд, намын гишүүн байсан хүмүүс чинь хэдийгээр шоронд байсан хэдий ч өөрийнхөө хамаг байдаг хүчээ шавхаж фронтод бэлэглэх ажилд оролцсон юм. Мөн түүнчлэн Төв засангийн мэдэлд олон салбар байсан л даа. Галттай ойн салбар /мод бэлтгэх салбар/, Налайхын чулуун нүүрсний салбарт 200-300 хүн ажилладаг байв. Туулаас дээш 70-80 км-т Галттай⁶³ гэж гол байдаг юм л даа. Тэнд мод бэлтгэлийн салбар байв. Мөн тэрчлэн Бэлхийн аманд ногооны газар, Өгийнуурт загас боловсруулах хэсэг хүмүүс, Богд ууланд түлээгээ бэлтгэх хүмүүс тус, тус ажиллаж байсан юм. Зөвхөн хоригдлуудын хүчээр л амьдрах, өөрсдийнхөө хүчээр л бэлтгэл гүйцэтгэл зэргээ хангах л зорилготой байсан. Би засанд 1940 оны намар очоод Аптекийн эм найруулагчаар ажиллахын зэрэгцээ Горбаренко⁶⁴ гэх эмчийн орчуулагч болов. Түүнийг дагасаар яваад л бага эмч болж, бүр итгэл аваад амбулаторын үзлэг хийдэг эмч болсон. Энд бас өндөр настай, өвчтэй зовлонтой хүмүүс байв. Ер нь шоронд байгаа улсын хамгийн гол аюул бол 2-3 зүйлийн өвчин байдаг юм билээ. Энэ нь уушгины сүрьеэ өвчин юм. Тэд чинь нарлах, цэвэр агаар амьсгалах бололцоогүй голдуу л битүү байшинд л хоригдож, гадуур гарах эрх байхгүй улсууд байдаг. Хоёрдугаар аюултай өвчин бол гэдэс ходоодны өвчин байдаг юмаа. Тэр нь хоол унд муу, ялангуяа 40-өөд оны эхний үед хоол унд хангалттай биш байсан. Чанарын талаар ч хангалтгүй байв. Жишээлбэл: өдөрт 3 хоол өгнө гэхэд, өглөөгүүр жаахан хар талх, хар

цайтай, өдөрт нэг хонины толгойг чанаад эрүү, толгой хоёрыг дундуур нь нэг салгаад 2 хүнд өгч байв. Орой бас тиймэрхүү жаахан хар талхтай. Иймд хоригдлуудын бие муудаж, гэдэс ходоодны талаар их хүнд болсон. Ялангуяа ар гэрийн талаар эргэлт муутай, дэмжих хүнгүй хүмүүс их хүнд байсан. Гуравдугаарт ядрах, турах, өлбөрөх явдал. Ийм гурван өвчин Төв Засанд голлож байлаа. Тэр үед ер нь витамин гэж эмнэлэгт байсангүй. Хамгийн дээд зэргийн чадалтай сайн эмчилгээ нь улаан, цагаан стрептоцид байсан юм. Одоогийнх шиг витамин С гэх мэт хүчтэй эмүүд байгаагүй. Төв Засан хэдийгээр эмнэлэгтэй байвч тийм хүнд өвчнийг эмчилж чадахгүй байв. Өдөр болгон л 10,20,30-аараа л ... тэгээд улсаас их арга хэмжээ авч хөнжил дэвсгэр, хоол ундыг нь ч жаахан сайжруулсан. Тэнд тусгайлан комисс энэ тэр гаргаж нилээн тусалсан. Гэлээ ч тэр өвчнөөр нилээд олон хүн хорогдсон. Ялангуяа тэр бөөсний тип өвчний дараагаар ядарсан улсуудыг амраах, хоол ундыг сайжруулах шаардлагатай байсан юм л даа. Гэтэл тэгээгүй. Ийм учраас түүний дараа цусан суулга өвчин дэлгэрч, тэр өвчнөөр олон хүн явсаан. Түүнд бид үнэхээр тус хүргэх чадалгүй байсан эмнэлэгийн талаар ч, хоол ундны талаар ч сайжруулах чадалгүй байсан. 1943 оны 5 дугаар сараас эхлээд тип өвчин гурван сар үргэлжилсэн. Би өөрөө ч их ядарсан. Би муурч унаад хэд хоног ухаангүй хэвтсэн байсан. Ингээд би дарга нараас “намайг хөдөө гаргаж өгөөч” гэж гуйсан. Намайг Зүүн Хараад шилжүүлж өглөө. Зүүн

⁶³ Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт Галттайн хойд нуруу, Галттайн гол, Галттайн урд нуруу байдаг.

⁶⁴ Горбаренко намтарын мэдээ тодорхойгүй.

Хараагийн лагерь том лагерь л даа. Газар тариалангийн лагерь. Тэнд 3000-аад хоригдлууд байсан. Үнээ саах ажилд голдуу эмэгтэйчүүд ажилладаг байсан. Хөдөөний байдал арай дээр байв. Цэвэр агаартай. Гадаа ажиллана. Тэндхийн хоригдлууд эрүүл мэндийн тал дээр арай дээр байсан болов уу гэж би боддог. Би тэнд жил гаруй ажилласан. Тэнд голдуу залуухан хоригдлууд /цэргийн хүмүүс/, бас алба хаагчид ч олон байлаа. Гэсэн ч өдөр нь ажиллаад шөнө нь цоожтой шавар нүхэн байшинд байгаа болохоороо уушгины өвчин их гарч, дэлгэрсэн. Ялангуяа шоронгийн нөхцөлд халдварт өвчин дэлгэрэх тун амархан юм билээ. Өвчин гарах сэжиг илэрмэгц хэд, хэдэн арга хэмжээ авсан л даа. Жишээлбэл Цагаан-Бурхан гарч хоёр хүн үхсэн байх. Иймд урьдчилан тариа хийсэн. Дараа нь нэгэн томуу дэлгэрэхэд каринтин тогтоож арга хэмжээ авсны үр дүнд гайгүй өнгөрсөн. Харин тэр үед орон нутагт хоёр нарны хооронд ажил хийж байсан хоригдлуудын биеийн эрүүл мэнд нилээд сайжирч, төвд хоригдож байгаа улсаа бодвол арай дээр санагдсан л даа.

Би тэнд жил шахам ажиллаж байтал 1944 онд Бороогийн сангийн аж ахуйд халдварт гэдэсний өвчин гарлаа гэж тийш нь намайг явууллаа. Нэг л шөнө “юмаа аваад гар” гэхээр нь гараад явлаа. Тэгтэл харин Бороод аваачлаа. Тэнд Балжинням⁶⁵ гэдэг даргатай /хуучин бас хэлмэгдэлд орсон хүн/ лагерь байв. Тэнд больниц энэ тэр зохиож, харин тэр Бороогийн лагерьин дарга нь ч жаахан зовлон үзсэн хүн болоод тэр үү, нэлээн бололцоо надад олгож, эм тан ч овоо хүрэлцээтэй

олгож, төсөв зардал олгож хот явж эм, тан авхуулав. Мөн түүнчлэн бие муутай ядарсан хоригдлуудад эмнэлэгийн бичгээр нэмэгдэл сүү, сүүтэй цай, хоол ундыг сайжруулах нэмэгдэл арга хэмжээ авч өгсөн. Ийм учраас тэнд байдал нилээд сайжирсан. Би 1944 оны өвөл хүртэл тэнд ажилласан. 1944 оны өвөл Балжинням өөрөө Ингэт Толгойн лагерь руу шилжив. Тэр бол бас хөдөө аж ахуй, газар тариалангийн лагерь байв. Тэнд 1000 гаруй хоригдлууд байсан. Голдуу Архангай, Увс, Ховд зэрэг баруун аймгуудаас ирсэн хоригдлууд байсан. Тэнд харин уушгины сүрьеэ, гэдэс ходоодны өвчин их цөөн байлаа. Онцлог нь юу вэ? гэвэл газар нутаг хол, эргэлт тойролт байхгүй тийм хүмүүс байв. Би тэнд Октябрийн баяраас өмнөхөн очсон юм. Уушгины хатгаа нилээн байв. Тэр ч аргагүй юм тэр хоригдлууд зуны хувцастай байсан. Тэр өвөлдөө би тэндээ байж, 1945 оны өвөл суллагдсан. Би суллагдаад Улаанбаатарт ирж их сургуульд орох гэж байсан юм л даа. Тэгтэл уушгины хатгалгаа их байсан хоригдлууд дунд Архангайн нэг хүн, Увсаас хоёр, гурван цэргийн дарга нар хүнд хатгаатай байсан. Миний оронд үлдэх эмч байхгүй байсан тул би үлдэхээс өөр аргагүйд болж 1946 оны зун хүртэл би тэндээс салж чадаагүй. Өвчтэй хүмүүсийг би суллагдсан ч гэсэн хаяж чадаагүй юмаа. Тэгэхдээ би цалин авч байсан. Адилхан зовж байсан болохоор хүнд өвчтэй нөхдөө хаяад ирэх зүрх хүрдэггүй юм билээ. 1946 оны зун Улаанбаатарт бүр мөсөн ирсэн. Тэгээд би их сургуульд орсон. 1949 онд Их сургуулийн түүхийн ангийг гэрээр

⁶⁵ Балжинням намтарын мэдээ тодорхойгүй.

төгссөн. Надад Машлай⁶⁶ сайд, Нацаг гэх мэт олон хүн тусалсан. Би бас Ширэндэвт⁶⁷ ч их баярлаж явдаг юм. Яагаад гэвэл намайг 1930-аад оны үед Гэгээрлийн яаманд байж байхад Ширэндэв энэ тэр хойшоо сургуульд

явахдаа миний гараар дамжиж явсан юм. Эдний тус дэмжлэгээр их сургуульд орж хоёр дахь удаагаа дээд сургууль төгссөн юм. Их сургууль 1949 онд төгсөөд хуучин ажилдаа Гэгээрлийн яаманд орсон.

⁶⁶ Түнжингийн Машлай (1915 - 1984) Ардын Гэгээрлийн сайд, МУИС-ийн анхны захирал, МУБИС-ийн захирал байв. 1940 оноос БНМАУ-ын Ардыг Гэгээрүүлэх Яамны сайд, Улсын Багшийн Институтийн захирал, 1956-1960 онд МУИС-д Сурган Хүмүүжүүлэх ухаан, Сэтгэл судлалын багш, тэнхимийн эрхлэгч, 1960 оноос Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Аспирантурын хэлтсийн дарга, МАХН-ын Төв хорооны Боловсон хүчний хэлтсийн даргаар тус тус томилогдон ажиллаж байжээ.

⁶⁷ Базарын Ширэндэв (1912 - 2001) Монгол улсын нэрт эрдэмтэн, түүхч, төр нийгмийн зүтгэлтэн хүн байв. 1944-1948 онд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга, 1954-1957 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга, 1962-1981 онд БНМАУ-ын ШУА-ийн Ерөнхийлөгч байв.

The Memoirs of “Barga” Erdembileg: In Foreign Hands

Batsaikhan Ookhnoi

Sc.D, Professor

Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,

Ulaanbaatar, Mongolia

batsaikhano@mas.ac.mn

Abstract: *In 1989, while working on the fifth volume of memoirs by senior Party members—an initiative led by the Institute of Social Sciences, I visited the home of an elderly man named “Barga” Erdembileg in a district of Ulaanbaatar. I met with him several times and conducted extensive interviews. Although the manuscript for this volume was completed in 1990, its publication was ultimately postponed due to financial and budgetary constraints.*

My task was to collect and compile interviews with prominent figures such as T.Bavuudorj, T.Genden, O.Dorj, and G.Erdembileg. This work took place during a period of political transition in Mongolia, between 1988 and 1989, when the reformist atmosphere emerging in the Soviet Union began to influence Mongolian society as well.

At that time, formerly repressed Party and state leaders, including D.Damba, Ch.Surenjav, and B.Shirendev, were once again permitted to speak publicly, occasionally delivering lectures at the Institute of Social Sciences.

This volume contains the memoirs of “Barga” Erdembileg, who migrated from Barga to Mongolia and later became a department head within the Ministry of Education of the Mongolian People’s Republic. In his vivid and detailed account, Erdembileg describes the revolutionary movement in Barga during the 1920s, his involvement in the Rebellion of 1928 in Barga, his subsequent studies in the Soviet Union, and his career at the Ministry of Enlightenment, where he was eventually arrested and repressed.

Key words: *Barga, Erdembileg, Inner Mongolia, Comintern, The Rebellion of 1928 in Barga*

The day of submission: 2025.09.06

Completion of review: 2025.10.23

Final decision for acceptance: 2025.11.10